

ФОЛЬКЛОРИСТИКА

УДК 398

DOI: 10.22162/2500-1523-2020-3-529-566



**Орос болон өрнө дахинд ойрад-халимагийн ардын дууг
цуглуулан тэмдэглэж, эмхэтгэж, хэвлүүлсэн тойм
(= История записи и публикации
народных песен ойрат-калмыков в России и Европе)**

Дамринджав Балжин¹, Баазр Александрович Бичеев²

¹ Институт национальных литератур Китайской академии общественных наук
(5, Цзяньго мэнь нань дацзе, 100732 Пекин, КНР)

доктор филологии, профессор

 0000-0002-7338-1030. E-mail: damrinjab@163.com

² Калмыцкий научный центр РАН (д. 8, ул. И. К. Илишкина, 358000 Элиста,
Российская Федерация)

доктор философских наук, ведущий научный сотрудник

 0000-0002-9352-7367. E-mail: baazr@mail.ru

© КалмНЦ РАН, 2020

© Дамринджав Б., Бичеев Б. А., 2020

Аннотация. *Введение.* Ойраты Китая, Монголии и калмыки России являются родственными народами, проживающими на территории трех стран. Ойраты Китая в основном проживают в Синьцзяне, Кукуноре, Ганьсу, Внутренней Монголии и Хармуре-не. В Монголии традиционные кочевья ойратов расположены в западных аймаках — Убсунурском, Кобдоском, Баян-Ульгийском, Завханском и Хубсугульском. Калмыки России проживают на территории Республики Калмыкия, а также в Астраханской области. Небольшие группы ойратов и калмыков есть в Кыргызстане, Европе и Америке. Несмотря на то, что уже на протяжении достаточно большого исторического времени ойраты и калмыки живут в разных странах и разных культурно-экономических условиях, они продолжают сохранять общую и богатую устно-поэтическую традицию, важной частью которой являются народные песни. Запись и сбор образцов ойратских и калмыцких народных песен в России и Европе начались 260 лет назад. Ойратские и калмыцкие народные песни по форме делятся на протяжные и короткие: первые исполняются в официальных случаях, таких как ритуалы, фестивали и праздники, а вторые — в обыденной жизни, в основном молодым поколением. *Цель* статьи — дать обзор истории собирания, изучения и публикации ойратских и калмыцких народных песен. *Результаты.* В настоящей статье дается анализ народных песен ойратов и калмыков, а также излагается целостная картина истории их записи, сбора и публикации в России и европейских странах в XIX–XX вв.

Ключевые слова: ойраты, калмыки, народные песни, жанры песен, история записи, публикация

Благодарность. Исследование выполнено при финансовой поддержке РФФИ и Академии общественных наук Китая в рамках научного проекта № 19-512-93002. «Фольклор народов Шелкового пути: ойрат-монголы Китая и калмыки России (от сказки к эпосу)». Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития–II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Дамринджав Б., Бичеев Б. А. Орос болон өрнө дахинд ойрад-халимагийн ардын дууг цуглуулан тэмдэглэж, эмхэтгэж, хэвлүүлсэн тойм (= История записи и публикации народных песен ойрат-калмыков в России и Европе) // Монголоведение. 2020. Т. 12. № 3. С. 529–566. (На монг.). DOI: 10.22162/2500-1523-2020-3-529–566

UDC 398

DOI: 10.22162/2500-1523-2020-3-529-566

Oirat-Kalmyk Folk Songs: a History of Recording, Investigating and Publishing in Russia and Europe

Danbuerjiafu (Damrinjav)¹, Baazr A. Bicheev²

¹ Institute of Ethnic Literature, Chinese Academy of Social Sciences (FL-11, West Wing, 5 Jiannei Dajie, Beijing 100732, People's Republic of China)

Dr. Sc. (Philology), Professor

 0000-0002-7338-1030. E-mail: damrinjab@163.com

² Kalmyk Scientific Center of the RAS (8, Ilshkin St., Elista 358000, Russian Federation)

Dr. Sc. (Philosophy), Leading Research Associate

 0000-0002-9352-7367. E-mail: baazr@mail.ru

© KalmSC RAS, 2020

© Danbuerjiafu, Bicheev B. A., 2020

Abstract. Introduction. Oirats of China, Mongolia and Kalmyks of Russia live in three different countries — but share common ethnic ancestry. Oirats of China primarily reside in Xinjiang, Qinghai, Gansu, Inner Mongolia, and Hara-Muren (Amur River valley). In Mongolia, Oirats traditionally inhabit western provinces, such as Uvs, Khovd, Bayan-Ölgii, Zavkhan, and Khövsgöl. In Russia, Kalmyks live in the Republic of Kalmykia and Astrakhan Oblast. Some minor Oirat and Kalmyk groups reside in Kyrgyzstan, Europe, and America. Despite being separated by historical eras, state borders and differing cultural-economic conditions, Oirats and Kalmyks still preserve the common vivid tradition of oral poetry largely represented by folk songs. In Russia and Europe, the earliest recordings of Oirat and Kalmyk folk songs were made 260 years ago. Those divide into lingering and short ones: the former serve to celebrate remarkable events, such as rituals, festivities and holidays; the former are usually sung by young people during regular household activities. **Goals.** The paper seeks to review the history of recording, investigating and publishing Oirat and Kalmyk folk songs. **Results.** The article analyzes folk songs of Oirats and Kalmyks, setting forth a coherent historical paradigm of theirs in Russia and European countries throughout the 19th and 20th centuries.

Keywords: Oirats, Kalmyks, folk songs, song genres, history of recording, publication

Acknowledgments: The reported study was funded by RFBR and CASS, project no. 19-512-93002 ‘Folklore of Silk Road Peoples: Oirat Mongols of China and Kalmyks of Russia (from Folk Tale to Epic)’. The article was presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Danbuerjiafu (Damrinjav), Bicheev B. A. Oirat-Kalmyk Folk Songs: a History of Recording, Investigating and Publishing in Russia and Europe. *Mongolian Studies (Elista)*. 2020. Vol. 12. No. 3. Pp. 529–566. (In Mong.). DOI: 10.22162/2500-1523-2020-3-529-566

Оршил

Манай авьяас билигт Ойрад-Халимагийн олон овог аймаг маань Монголын бусад овог аймгуудын нэгэн адилаар аман зохиолын өвөөр баялаг уламжлалтай бөгөөд түүний төрөл зүйл нь ч олон юм. Тухайлбал: баатарлаг тууль (эпос), аман яруу найраглал¹, ардын дуу, ерөөл магтаал, хараал, үлгүүр (үлгүр)², ахар тууль³, орчлонгийн гурван болон дөрвөн⁴, ут тууль⁵ гэх мэт олон төрөл зүйл

¹ Аман яруу найраглал — агуулгаараа шидэт үлгэр, аж байдлын үлгэр, амьтны үлгэртэй адил буюу ойролцоо, хэлбэрийн талаараа шүлэглэсэн төрөл зүйл. Хятадаар ийм төрлийг 叙事诗 гэнэ. Энэ нь хэдэн зуун мөр буюу хэдэн мянган мөр шүлгээс бүтсэн байх нь бий. Энэхүү төрөл зүйл нь манай монгол, буриад болон ойрад-халимагийн аман зохиол дотор нэлээд түгээмэл тохиолдоно. Харин энэхүү төрөл зүйлийг Өрнө дахинд туульсийн зохиол хэмээн үздэг. Ийм онцлог манай ардын аман зохиолын бусад төрөл зүйлд ч мөн нэгэн адил тохиолдоно. Жишээлэхэд: үргэлжилсэн хэлбэрээр байвал домог үлгэр 神话 хэмээн нэрлэх ба харин түүнийг шүлгээр хэлбэл домоглог тууль (神话史诗) буюу галавыг үүдсэн тууль (创世史诗) хэмээн нэрлэж байна. Ийм домоглог тууль манай улсын өмнө орны цөөн тоот үндэстэнд тун элбэг байгаа юм.

² Үлгүүр (Үлгүр) — энэ нэр томъёогоор зүйр цэцэн үгийг нэрлэж байна. Монгол хэлэнд үлгэр гэж уншигддаг энэ үгийг ойрад болон халимагийн дөрвөд, торгууд, хошууд, бузав хүмүүс бүгд үлгүүр (үлгүр) гэж хэлдэг. Үлгүүр нь зүйр цэцэн үгийг заахаас гадна бас ойрад-халимаг нарт жишээ гэх утгаар ойлгогдоно. Иймээс үлгүүр үг гэдэг нь үг цөөн боловч утга гүн, аливаа хэрэг учрын цаадахь шинж чанарыг олж хэлсэн, хүмүүст жишээ болох, үг хэлэхэд жишээ татах, үгнүүдийн дотор хамгийн сайн үгнүүд буюу үгийн охинууд болох юм. Тус үг нь мөн үлхүүр (үлхүр) гэж бас хэлэгддэг. Энэ нь хувцас эсгэхэд хэрэглэх хувцасны загварыг заахаар барахгүй мөн бас хүмүүст дууриалал болох гэсэн утгатай байгаа юм.

³ Ахар тууль — энэ нь оньсогыг зааж буй. Шинжааны ойрад болон халимаг хүмүүст тууль гэдэг үг нь хоёр зүйл утга буй. Нэг нь аман үлгэрийг хэлдэг. Нөгөө нь онсогыг хэлдэг юм. Нэн тодруулж хэлбэл, ут тууль (урт тууль) нь домог үлгэр болон домгийг багтаасан үргэлжилсэн үг бүхий аман үлгэрийг заадаг. Ахар тууль нь зөвхөн оньсогыг заадаг. Ахар туулийг бас тайллага-тай тууль (тээллхтэ тууль), тайлбартай тууль (тээлвртэ тууль) гэж ч нэрлэдэг билээ.

⁴ Орчлонгийн гурван болон дөрвөн (Орчлңгин гурвн болн дөрвн) — энэ нь ертөнцийн гурав болон дөрвийг зааж байна. Шинжааны ойрад болон халимаг хүмүүс ертөнцийн гурав болон дөрөвийг орчлонгийн гурван болон дөрвөн гэдэг билээ. Мөн Шинжааны зарим нутагт Орчлонгийн дөрвөн хөк (Орчлңгин дөрвн хөк), Орчлонгийн арван хоёр хөк (Орчлңгин арвн хойр хөк) гэдэг юм.

⁵ Ут тууль — урт тууль. Энэ нь домог, домог үлгэрийг багтаасан үргэлжилсэн үгийн аман үлгэрийн ерөнхий нэрийдлэг юм. Тодруулж хэлбэл, Шинжааны Алтайн урианхай, Ховогсайрын торгууд, Ар Тарвагтайн өөлд, Хар-Усны торгууд хүмүүс домог, домог үлгэрийг багтаасан үргэлжилсэн үгийн хэлбэр бүхий үлгэрүүдийг туух, оньсогыг тууль, судар бичгээр бичигдсэнийг тууж хэмээн нэрлэдэг. Борталын цахар, Жингийн торгууд, Илийн Нялх, Монголхүрээ, Тэхэсийн өөлд торгууд хүмүүс нь домог, домог үлгэрийг багтаасан үргэлжилсэн үгийн хэлбэр бүхий аман үлгэрийг тууль гэж, оньсогыг оньсого гэдэг билээ. Баянголын 54 суман торгууд болон 10 суман хошууд хүмүүс домог, домог үлгэр, явган үлгэр болон «Жангар»-ыг бүгдийг нь «Жангар» гэж нэрлэдэг жишээтэй. Харин ОХУ-ын Халимаг улсын хүмүүс домог үлгэрийг болон домгийг багтаасан бүх үргэлжилсэн үгийн аман зохиолыг ут тууль (урт тууль) гэдэг.

байдаг. Зөвхөн ут тууль (урт тууль) гэхэд тэр нь дотроо бас баатарлаг тууль⁶, сидэт тууль⁷, байцын тууль⁸, дамбараллаганы тууль (дамбрллна тууль)⁹, ан адуусны тууль (ан адусна тууль)¹⁰, домог болон туужис гэх мэт олон зүйл буй.

Ойрад-Халимагийн аман зохиолын олон төрөл дотор ардын дуу нь тун ч чухал байр суурийг эзэлдэг юм. Ойрадууд ардын дуугаа ут дуун¹¹ болон хохир

⁶ Баатарлаг тууль — баатарлаг үлгэр, баатрын үлгэрийг зааж байгаа юм. Энэ нь одоогийн ном дэвтэр дээр байгаа буюу эрдэмтэн судлаачдын хэлдэг баатарлаг тууль, баатрын тууль (英雄史诗, эпос) бус харин үргэлжилсэн үгийн хэлбэртэй, явган үлгэрийн доторх биеэ даасан нэг төрлийг зааж буй. Ойрад-Халимагийн аман үлгэрийн дотор баатрын үлгэр буюу баатарлаг үлгэр тун олон бөгөөд одоо их төлөв 500-аад ийм үлгэр мэдэгдээд байна.

⁷ Сидэт тууль — шидэт тууль. Энэ монгол ардын шидэт үлгэрийг зааж байна. Халимагийн эрдэмтэд ийм үлгэрийг *сидэтэй тууль* (*сидтэ тууль*), *илбэтэй тууль* (*илвтэ тууль*), *хувилгаан-тай тууль* (*хувлхэтэ тууль*) гэж хэлдэг. Аман зохиолын доторх ийм төрөл зүйлийг хятадаар 魔法故事, 神奇故事, 幻想故事, 童话 гэх мэтээр нэрлэнэ. Ийм төрөл зүйлийг Монгол улсын эрдэмтэн судлаачид болон Оросын холбооны Халимаг, Буриадын эрдэмтэн судлаачид аль эртнээс *шидэт үлгэр* гэж, *шлг-г домог үлгэр* гэж нэрлэсээр ирсэн билээ. Харин манай улсын зарим эрдэмтэд дэлхийн монголч эрдэмтэн судлаачид аль эртнээс нэрлэсээр ирсэн буюу хүмүүс нэрлэсээр нэгэнт заншсан нэрийдлэгийг үл хайхран *шидэт үлгэр*-ийг *увдист үлгэр* гэж, *домог үлгэр*-ийг нь *шидэт үлгэр* гэж нэрлэн ном зохиол, өгүүлэлдээ бичсээр байгаа юм. Би бодож үзвээс, энэхүү эрдэмтэн мэргэд нэг болбоос дэлхий дахинд монголч эрдэмтэд аман зохиолын доторх ийм төрөл зүйлийг хэрхэн нэрлэж байгааг огт олж үзээгүй буюу бүр ойлгож мэдэхгүйгээс болсон байж мэднэ. Хоёрт, өөрөө мэргэлж шинэ шинэ нэр томьёо зохиох гэж оролдсон оролдлого байж ч мэднэ. Гуравт, хятад үгийг махчилан орчуулж 魔法故事, 神奇故事 гэдгийг нь увдист үлгэр, 神话-ийг шидэт үлгэр гэж нэрлэсэн зүйл байдаг гэдгийг ч үгүйсгэхийн арга алга. Сайн судалгаа гэдэг нь зөвхөн нэр нэрийдлэг, нэр томьёог сольж холиход буюу өөрчлөхөд байгаа биш гэдгийг эрдэмтэд сайтар бодож, хойшдоо хичээж ажиллах юм. Нэг үндэстэн нэг л юмны нэг нэрийдлэгийг улс улс, газар газар, олон их дээд сургууль болон судалгааны байгууллага, хүн болгон адилгүйгээр өмнө өмнөө нэрлэвэл манай судалгаанд самуурлыг авч ирэхээр үл барам дэлхийн монголч эрдэмтдийг төөрөгдөлд хүргэх болно. Энэ нь манай судалгаанд ямар ч ашиггүй зүйл гэдэг нь хэн бүхэнд тун тодорхой буюу.

⁸ Байцын тууль — энэ нь аж байдлын үлгэрийг зааж буй. Мөн бас байдал жаргалын тууль гэж ч нэрлэж байгаа билээ.

⁹ Дамбараллаганы тууль (дамбрллна тууль) — энэ нь хошин шог үлгэр, хошин шогтой үлгэр гэсэн утга бүхий үг. Мөн бас *хохирлагч тууль* (*хокрлч тууль*) гэж ч нэрлэж буй.

¹⁰ Ан адуусны тууль (Ан адусна тууль) — энэ нь амьтны үлгэрийг зааж буй. Мөн бас *ан агуурсны тууль* (*ан-агурсна тууль*) гэж ч нэрлэдэг юм.

¹¹ Ут дуун — урт дуу. Энэ нь уртын дуу гэсэн утгатай үг. Шинжааны ойрадууд урт аятай, мөн бас жинхэнэ баяр цэнгэл, хурим найр, шашин шүтлэгийн хөдөлгөөн зэрэг жинхэнэ ёслол дээр дуулдаг, зан үйл, зан заншилтай холбогдол бүхий дууг ут дуун (урт дуу) гэдэг. Ойрадын ут дуун (урт дуу) болон ерөөл магтаал нь ойрадын зан үйл, зан заншил болон шашин шүтлэгийн зүйл бүрийн хөдөлгөөн буюу ёслолтой нарийн нягт холбоотой байдаг. Тиймээс ойрад хүмүүс нь найр цэнгэл, хурим гийч буюу ямар нэгэн ёслолд очиж оролцохдоо ут дуун (урт дуу) болон ерөөл магтаалыг аяндаа сурчихдог бөгөөд залуу настай хүн хүртэл тавь жаран эхэн ут дуу (урт дуу) мэддэг байсан билээ. 80-аад оны үед би хээрийн шинжилгээгээр явж байхад дал наян настай хөгшид олон байсан бөгөөд тэдний дотор 200 гаруй ут дуу (урт дуу) мэддэг нэртэй дуучид ч олон билээ. Эдүгээ тэдний олонх нь таалал болсон. 90-ээд оноос эхлэн зах зээлд шилжиж нийгэм болон хүмүүсийн амьдралд асар их хувиралт гарч эхэлсэн байдаг. 90-ээд оноос аван нийгмийн хувиралт өөрчлөлтийг даган манай ойрадын уламжлалтай зан үйл, зан заншил болон ардын аман зохиолын олон төрөл зүйлд нь тун ч хувиралт гарч эхэлсэн буюу гарсан байдаг. Жишээлэхэд, урьд нь жинхэнэ найр цэнгэл, хурим гийч болон бусад ямар нэгэн ёслолд бүр ут дуу (урт дуу) дуулдаг байсан бол эдүгээ цагт тэр ёс нь алдагдаж залуучууд голдуу хохир дуу (хокр дуу), орчин үеийн зохиолын дуу дуулах болсон бөгөөд зарим нэгэн ут дуу (урт дуу)-ны үгийг нь хохир дуунд оруулах, ут дуун (урт дуу) болон хохир дууны үгийг нь дураараа сольж хутгах, газар газрын адилгүй дууны аяаг нь дураараа хооронд нь сольж хутгах, ут дуун (урт дуу)-ы цэгийг өмнөх болон хойнохыг нь тонгоруулах, ут дуун (урт дуу) болон хохир дууны нэрийдлэгийг нь дураараа нэрлэх гэх мэт

дуун (хокр дуун)¹² хэмээн хоёр зүйлд хуваадаг. Урт аятай, бас жинхэнэ баяр цэнгэл, хурим найр, шашин шүтлэгийн хөдөлгөөн зэрэг ёслол дээр дуулдаг, зан үйл, зан заншилтай холбогдол бүхий дууг ут дуун (урт дуу) гэдэг бөгөөд найр жаргал, баяр цэнгэл, хурим найр болон шашин шүтлэгийн ямар нэгэн хөдөлгөөн зэрэг жинхэнэ ёслолд ер нь дуулдаггүй, хээр гадна голдуу залуучууд дуулдаг, охор богино ая бүхий дууг хохир дуун (хокр дуун) гэдэг билээ. Үнэнийг хэлэхэд, хохир дуун нь залуу хүмүүсийн хайр сэтгэлийг илтгэсэн буюу хошин шог дуу олон боловч, тэр нь бүгдээрээ тийм утга агуулгатай биш бөгөөд мөн бас нутаг усаа санан мөрөөдсөн, нутаг усаа магтсан, аав ээжийнхээ энэрэл хайр, ач гавьяаг нь магтан дуулсан, найз нөхдөө санан мөрөөдсөн гэх мэт олон агуулгатай байдаг билээ. Тухайлбал, «Өндөр өндөр ууланд» гэх дууг хүмүүс сайн мэднэ. Тэр нь хүмүүс торгууд нутгаа санан мөрөөдсөн дуу болно. Энэ мэт дуунууд олон байдаг билээ. Мөн тэрчлэн түүхийн нэгэн хэрэг явдлыг харуулсан, түүхт баатраа магтсан буюу мөрөөдөн санасан утга агуулга бүхий дуу ч олон байдаг юм. Жишээлбэл, «Усны эхэнд хонхолзуур ганцаараа» гэдэг дуу байдаг. Энэ нь баатар эр Галдамаа (Галдамбаа)-г магтан дуулсан дуу болно. Гэхдээ ийм утга агуулгатай буюу өнгө аястай дуу олон байдаг боловч энэ нь ахар богино аятай зэрэг олон зүйлийн учир шалтгаанаас болж жинхэнэ баяр цэнгэл, хурим найр, гийч тоовор болон овоо тахих, гал тайх (гал тахих), зулын баяр, сүм хийдийн баяр зэрэг зүйл бүрийн ёслолд огт дуулдаггүй маш хатуу журам буй¹³. Ойрад-Халимаг хүмүүс ут дуу (урт дуу)-гаа гэгээн богд, хувилгаан хутагтын дуун¹⁴, лам хуврагийн дуун¹⁵, сайд ноёдын дуун¹⁶, олон асуудал оршиж байгаа юм. Жишээлхэд, хохир дууг (хокр дууг) *шоитир дуу*, ут дууг *уртын дуу* гэх мэтээр нэрлэдэг болсон байна.

¹² Хохир дуун (хокр дуун) — найр жаргал, баяр цэнгэл, хурим найр болон шашин шүтлэгийн ямар нэгэн хөдөлгөөн зэрэг жинхэнэ ёслолд ер нь дуулдаггүй, хээр гадна голдуу залуучууд дуулдаг, охор богино ая бүхий дууг хохир дуун (хокр дуун) гэдэг. Хохир дууг Шинжааны Илийн өөлд болон торгууд хүмүүс *хохир дуун (хокр дуун)* болон *хохир яхир дуун (хокр якр дуун)* гэж нэрлэдэг, Борталын цахар хүмүүс *шоитир дуун* гэдэг. Бархөлийн монголчууд *завхай дуун* гэхэд, харин халимаг хүмүүс *ахар дуун* гэж ч нэрлэж буй.

¹³ Ойрадуудын хурим гийч болон ямар нэгэн найр цэнгэл, шашин шүтлэгийн хөдөлгөөн зэрэг ёслолд оролцоходоо ер нь ут дуу (урт дуу) дуулахаас бус хохир дуу (хокр дуу) дуулдаггүй хатуу ёстой бөлгөө. Архи барихыг дуугүй сөн болон дуутай сөн гэж хоёр хуваадаг. Найр цэнгэл, хурим гийч болон ямар нэгэн ёслолд ирсэн зочиндоо урьдаар дуугүй архи барьж, хойно нь дуутай архи барьдаг. Ямар нэгэн ёслол дээр дуу дуулахгүйгээр урьдаар архи барьдгийг нь дуугүй сөн гэж, дуутай архи барьдгийг нь дуутай сөн гэдэг. Дуу дуулахдаа заавал ут дуу (урт дуу) дуулдаг юм. Ут дуун (урт дуу) нь хохир дуутай адилгүй, тэр нь ойрадын зан заншил, зан үйл болон шашин шүтлэг зэрэгтэй тун ч нягт харьцаа холбоотой. Ямар нэгэн зан үйл гүйцэтгэхдээ ямар үед ямар урт дууг дуулж болох хатуу ёс буй. Буруу дуу дуулбаас хэрүүл ч гарах явдал гардаг.

¹⁴ Гэгээн богд, хувилгаан хутагтын дуун — гэгээн богд, хувилгаан хутагт зэрэг хүмүүст дуулдаг тусгай дууг гэгээн богд, хувилгаан хутагтын дуун гэдэг. Жишээлбэл, «Газрын холд жороолдог алтан шарга морин», «Хайч чихтэй хар», «Зэ Баруун Номун хааны шавь нар», «Согоо чихтэй шаргал», «Үүлэн хүрээлсэн уул» гэх мэт олон ут дуун (урт дуу) байдаг.

¹⁵ Лам хуврагийн дуун — найр цэнгэл, хурим гийч болон шашин шүтлэгийн ямар нэгэн хөдөлгөөнд тусгайлан лам хүмүүст дуулдаг нэг хэсэг дуу байдаг, ийм дууг лам хуврагийн дуун гэдэг. Жишээлбэл, «Онц сайхан ургац», «Гүндэйлэгийн сүм» (Гүндэлцгин сүм), «Дам дамын уул», «Уран тагнайн цулбуур», «Номхон бор морин», «Өргөн Туулийн хөвөөд», «Их бага хоёр шарга», «Мэлмэгэр нуурын хөвөөд», «Тэвэг дэлтэй эрэвгэр шаргал», «Шар талын бургасан», «Хонгор шаргын тарганд», «Богд Сайрамын орой» гэх мэт олон ут дуун (урт дуу) байдаг юм.

¹⁶ Сайд ноёдын дуун — эрт дээр үед хан, ван, гүздэй (гүздэ), бэйл, бэйс, мэйрэн гэх мэт сайд ноёдод дуулдаг тусгай ут дуу (урт дуу)-г сайд ноёдын дуун гэдэг. Жишээлбэл, «Сав их ертөнц», «Барим дэлтэй бор», «Үлэмж буянаар учрахын цагт», «Алтайн ар дэнж дээр», «Хашил зандан

аавын дуун¹⁷, ээжийн дуун¹⁸, аакийн дуун¹⁹, ахын дуун²⁰, эгчийн дуун²¹, үүр ханийн дуун²², дүүгийн дуун²³, хайр сэтгэлийн дуун²⁴ гэх мэтээр ангилдаг юм.

хар», «Өндөр Сайрамын орой», «Манлай тохойн хөх сүүл», «Хан уулын оройд», «Хүдрэн гарах наран», «Богдын их хишиг рашаан» гэх мэт олон ут дуун (урт дуу) буй.

¹⁷ Аавын дуун — Ойрад-Халимагууд өөрийн төрсөн ааваа адай (эдэ), эцэг гэж, өвөг аав, өвөөгөө аав гэж дууддаг бөгөөд нэлээд настай эрэгтэй хүмүүсийг ч аав гэж нэрлэдэг билээ. Аавын дуун гэдэг нь өвөг аав, өвөө болон нэлээд настай эрэгтэй хүмүүст тусгайлан дуулдаг ут дуу (урт дуу)-г хэлдэг. Энэ ут дуу (урт дуу)-г дуулж өөрийн төрсөн эцэгтээ ч барьдаг ёс буй. Жишээлбэл, «Өндөр замын эхэнд», «Өргөн их ижил зай», «Сааль тохойн модон», «Сайхан хангайн буга», «Алтай хангайн шил», «Цагаан тохойн нутаг», «Цагаан шаргал морин» гэх мэт олон дуун байдаг.

¹⁸ Ээжийн дуун — Ойрад-Халимаг хүмүүсийн олонх нь өөрийн төрсөн ээжээ мээмэй (меема), эх гэж, эмэг ээж, эмээгээ ээж гэж дууддаг бөгөөд нэлээд настай эмэгтэй хүмүүсийг ч ээж гэж нэрлэдэг билээ. Ээжийн дуун гэдэг нь эмэг ээж, эмээ болон нэлээд настай эмэгтэй хүмүүст тусгайлан дуулдаг ут дуу (урт дуу)-г хэлдэг. Энэхүү дууг дуулж өөрийн төрсөн эхдээ ч барьдаг ёс буй. Жишээлбэл, «Будал уулын оройд», «Хөвчийн түрүүгээр гүйдэлтэй», «Хангинасан хар», «Саяг саяг саарал», «Манж тамгатай бор», «Ганзагын эхэн шил», «Богдын их хүрээ», «Улаан булгийн усан», «Могой нүдэн хээр» гэх мэт олон ут дуун (урт дуу) буй.

¹⁹ Аахийн дуун (Аакин дуун) — насаар өөрийн эцгээсээ бага, ахаас насаар их хүнийг; мөн ямар нэгэн ноён хэргэм бүхий эрэгтэй хүмүүс болон төрөл садны эрэгтэй ахмад хүнийг; мөн бас нэлээд настай нутаг усандаа хүндэт эрэгтэй хүмүүсийг ойрад нутагт *аак* гэж нэрлэдэг. Ийм хүмүүст тусгайлан дуулдаг урт дуунуудыг аакин дуун буюу аакид дуулах дуун гэдэг билээ. Жишээлбэл, «Буга биетэй халтар», «Артай бага шарга», «Орын ганц модон», «Барим дэлтэй бор» (мөн ноёд сайд ч дуулж болдог), «Өндөр замын эхэн» (аавд ч дуулж болно) гэх мэт олон ут дуун буй. Аак гэдэг үг нь ойрад-халимагийн адилгүй газар нутаг, овог аймгийн дотор хоорондоо бүр адилгүй утгаар хэрэглэгдэж байгаа. Жишээлбэл, зарим нутагт эцгийгээ аак гэхэд, зарим нутагт авга бэргэнээ аак гэдэг. Мөн зарим газарт ноёны хүүхнийг аак гэхэд, харин зарим нэгэн газар нь өөрийн эхийгээ аак гэдэг жишээтэй. Тус өгүүлэлд Эрэн хавиргын Хүр Хар-Усны долоон суман торгуудын вангийн дөрвөн сумын торгуудын ут дуугаар жишээ татав.

²⁰ Ахын дуун — Ойрад-Халимаг хүмүүс өөрийн төрсөн ах буюу өөрийн биеэсээ нас ах хүнийг ах гэж нэрлэдэг. Ийм ах хүмүүст тусгайлан дуулдаг ут дууд (урт дуунууд)-ыг ахын дуун гэх буюу ахад дуулдаг дуун гэнэ. Жишээлбэл, «Ногттойгоо шаргидаг», «Уяны хонгор салхин», «Жигүүртэй шарга морин», «Буга биетэй халтар», «Хүдэр ядар хүрэн», «Хилин сайхан хар», «Нарны баахан шарга» (голдуу нагацдаа дуулдаг дуу), «Бэрх уулын буга», «Саадгийн даруулга», «Бичгэн хааны хээр», «Уужим сайгийн усан», «Гүн өнгөтэй зээрд», «Адуунд нь байсан бор» гэх мэт олон ут дуун (урт дуу) байдаг.

²¹ Эгчийн дуун — Ойрад-Халимаг хүмүүс өөрийн төрсөн эгч буюу өөрийн биеэсээ нас ах эмэгтэй хүмүүсийг эгч гэж нэрлэдэг. Ийм нас ах хүмүүст тусгайлан дуулдаг ут дуудыг (урт дуунуудыг) эгчийн дуун гэнэ. Тухайлбал, «Бужуу хангайн буга», «Алтай намар (арал)-ын амтан сайхан», «Худаг шандын усан», «Сээр дээр чинь ургагч сэнсэлсэн сайхан харгай» (эгч болон бэргэнд) гэх мэт олон ут дуун (урт дуу) буй.

²² Үүр ханийн дуун — найз нөхдийн дуу гэсэн утга бүхий үг. Багаасаа харилцан ижилсэн нөхөрлөсөн дотно нөхөд буюу үеийн хүмүүст тусгайлан дуулдаг ут дуудыг (урт дуунуудыг) үүр ханийн дуун гэдэг. Жишээлбэл, «Гуруу чихтэй хээр», «Алхалангийн зээрд», «Баяр дарын шуураа», «Эрвэн жороо бор», «Алтай зайрын шил», «Загалмай тамгатай бор», «Найман сарын навч», «Үүлэн солонго бор» гэх мэт олон ут дуун (урт дуу) буй.

²³ Дүүгийн дуун — өөрийн биеэсээ насаар бага хүмүүсийг дүү гэдэг. Ийм хүмүүст тусгайлан дуулдаг ут дуудыг (урт дуунуудыг) дүүгийн дуун гэх буюу дүү нарт дуулах дуун гэнэ. Жишээлбэл, «Улаан шимээлийн усан» (Улан шимэлин усн), «Хэнз бага хээр халтар», «Хангайн буурал морин», «Хээр халтар морин», «Сэмэн дэлтэй цавьдар», «Бугаальг бугаальг бор», «Наадай голын эхэн», «Намарга ихтэй харгай», «Уралдаанд шөвөглөгч ууд холбоо халтар» гэх мэт олон ут дуун (урт дуу) байдаг юм.

²⁴ Хайр сэтгэлийн дуун (хээр седклин дуун) — энэ нь янаг амрагийн дуу буюу хайрын дуунуудыг хэлж буй. Ийм дуунуудад «Дааган дэлийн шуураа», «Хүрэн хүрэнний жороо», «Мөнгөн тахтай хээр», «Минжийн хангайн буга», «Адуунд нь байсан бор», «Загасан болсон хээр», «Хархилангийн тогоруун» (Хэрклцгин тоһрун), «Хонгор өлөнгийн шуураа» гэх мэт олон ут дуун (урт дуу) байдаг билээ.

Үүнээс гадна баяр найр, хурим гийч эхлэхэд найрын эхэнд дуулдаг дууны эхэн дуун²⁵ гэж байдаг бөгөөд найр цэнгэл, хурим гийч төгсөхөд дуулдаг найрын төгсгөл дуун²⁶ гэж ч байдаг. Мөн бас хүүхэн урих буюу хүүхэн цайлуулахад, хүүхэн хуримлахад хуримлаж байгаа хүүхэнд дуулдаг тусгай олон дуунууд ч буй²⁷. Мөн түүнчлэн хуримлахад хүргэнд хүүхний талын бэргэнүүд нь бүс бүслүүлэхэд дуулдаг тусгай дуу бас байдаг юм²⁸. Ойрад-халимаг хүмүүс ут дуу (урт дуу)-гаа дуулахдаа мэддэг буюу ямар нэгэн санаанд орсон дуугаа дураараа дуулж, ирсэн зочиндоо архи барьдаг бус харин ямар дууг ямар цагт нь дуулах,

²⁵ Дууны эхэн дуу (дууна экн дуун) — Шинжааны Ойрад хүмүүс ямар нэгэн найр жаргал, хурим гийч болон ямар нэгэн ёслол хийхдээ урьдаар дууны эхэн дуугаа дуулж эхэлдэг ёс горимтай. Шинжааны Ойрадын газар газрын, нутаг нутгийн дууны эхэн дуу нь адилгүй боловч олонх газар нутагт «Бурхан шашин огторгуй» гэдэг дууг дуулж найр жаргал, хурим гийч болон зүйл бүрийн ёслолоо эхлэн явуулдаг билээ. Бас зарим газарт «Улаан эрэнгийн усан», «Хүч ихтэй арслан» гэх мэтийн дууг ч дуулдаг явдал буй. Ер нь найр цэнгэл, хурим гийч болон ямар нэгэн ёслол эхлэхэд дууны эхэн дуугаа урьдаар дуулж, тэр гэрт суугаа олон хүмүүс дотроос хамгийн хүндэт хүнд сөнгөө өргөх ёстой. Жишээлбэл, гэгээн богд, лам хувраг, ноёд сайд, аав ээж гэх мэт дараагаар өргөнө. Найр цэнгэл, хурим гийч, ёслолд гэгээн богд морилон саатсан болбоос тэр хүнд дуутай сөнгөө барьдаг. Хэрэв гэгээн богд байхгүй харин лам хувраг саатсан бол түрүүлэн дуутай сөнгөө лам хуврагтаа барьдаг. Гэгээн богд, лам хувраг морилон ирж саатсангүй болбол сайд ноёдод дуутай сөнгөө барьдаг ёс буй. Дууны эхэн дуугаа барьсны хойно гэрт байгаа хүмүүсийн байдал, насны их баггыг үзэж нялх хүүхдийг хүртэл үлдээлгүй дуутай сөнгөө нэг нэгээр өргөдөг юм. Дуутай сөн өргөх буюу дуутай сөн барихыг цэнгэл өргөх гэж ч хэлдэг билээ (Эрээн хавиргын Хүр Хар-Усны торгуудын ут дууны жишээ дээр).

²⁶ Найрын төгсгөл дуун — Шинжааны Ойрад нутагт дууны эхэн дуун гэж байхаас гадна бас найрын төгсгөл дуун гэж байдаг. Ямар нэгэн найр цэнгэл, хурим гийч болон ёслол төгсөхөд найр цэнгэл, хурим гийч болон ёслолд оролцогчдын дотроос хэн нэгэн ахмад хүн буюу хуримын ахлаачаас «Их сайхан хээр» гэдэг найрын төгсгөлийн дууг эхлэхэд хүмүүс бүгдээр тус дууг дуулж баран найр ёслол тарж хүмүүс цугтаа харьдаг ёс буй.

²⁷ Хүүхэнд алчуур хавчуулдаг дуун — эртдээ хүүхэн хуримлахаас арав буюу хорин хэд хоногийн өмнөөс эхлэн мордож байгаа хүүхнийг ах дүү, садан төрөл болон сайн найзууд нь гэртээ дуудан гийчлүүлэн хонуулдаг бөгөөд энэхүү ёслолыг ойрад хүмүүс хүүх урих (күүк үрх), хүүх цайлуулах (күүк цээлүх) гэх мэтээр нэрлэдэг юм. Хүүхэн урих, хүүхэн цайлуулахад, хүүхэн хуримлахад нь мордож байгаа хүүхэнд ах дүү, садан төрөл нь дуулдаг тусгай олон дуунууд байдаг. Тэрхүү дуунуудыг хүүхэнд алчуур хавчуулдаг дуун гэдэг. Үүнд: «Давхар шүдэн хээр», «Зайр талаас ниссэн загалмай шувуун хөөрхий», «Таваглаад өсгөсөн ботгон», «Урамгарын хурц наран», «Сайрамын нуурын усан», «Бүргэд шувуун болхуйн» (Бүргд шовун болхин), «Өл манхан буга», «Хар салаагийн шуураа», «Улаан буурал морин», «Нуурын уснаас тунгалаг», «Эвийн нуурын усан», «Марахын улаан цэцэг», «Хос хонгор морин» (Хош хонһр мөрн), «Жаргалтай сайхан хангай», «Ар салаагийн шуураа», «Сайхан тохойн шуураа» гэх мэт олон ут дуун (урт дуу) байдаг бөлгөө.

²⁸ Хүргэнд бүс бүсэлдэг дуун — өглөө эрт их хурим орсны хойно хүргэн хадмын гэрт нь орж ёсоо гүйцэтгэдэг. Хот хоол болсны хойно хүүхний талаас хүргэний ахлаач болон хүргэн дагагч залууст дуугүй архи, дуутай сөнгөө барьж өмсгөлөө өмсгөж ёсоо гүйцэтгэсний хойно хүүхний хоёр бэргэн нь хүргэндээ бүс бүсэлдэг ёсыг гүйцэтгэдэг. Тэр үед хүргэндээ «Төмөр цоргын эхэн» гэдэг ут дуу (урт дуу) дуулж дуутай сөн барьдаг билээ. Хүүхнийг аваад гарахад хүүхэн нь эцэг эхдээ «Завдаангүй бүрхдэг зайрын өндөр шил» гэдэг ут дуу (урт дуу) дуулж сөнгөө барьдаг. Хүүхнээ хүргэж очоод хүмүүс буцахдаа хүүхнийхээ хилэнцийг даалгаж хүргэний эцэг эхэд нь «Алтан сагмайтай алаг» гэдэг ут дуу (урт дуу) дуулдаг. Хэдэн хоногийн хойно хүргэн хадмындаа золгохдоо хадам эцэгтээ «Ар талын алтан хангай» гэх мэт ут дуу (урт дуу) дуулдаг. Үүнээс гадна хол замд гарах хүнд «Хонгор шаргын тарган» гэдэг дуу, хурим гийч, найр жаргалд сөн барьсан хоёр сөнчид «Адрага дундаа сүлжээтэй аман цагаан аргал» гэдэг ут дуу (урт дуу) дуулан сөн барьдаг ёс буй. Ойрадын зан үйлийн дотор ийм зүйл тун олон буй (Эрээн хавиргын Хүр Хар-Усны торгуудын ут дууны жишээ дээр).

ямар дууг дуулж аль хүнд барих, дууны хэддүгээр цэг²⁹ дээр нь зочиндоо архи барих³⁰ буюу хэдэн өдрөөр залган найрлаж жаргасан ч нэг дуугаа дахин давтан дуулдаггүй сайхан ёс горимтай билээ. Ойрадын ут дуун (урт дуу) болон ерөөл магтаал нь тэдний зан үйл, зан заншил, зүйл бүрийн ёслолтой нь тун нарийн нягт холбоотой юм. Иймээс дээр үед ойрад хүмүүс нь найр цэнгэл, хурим найрт очиж оролцох явц дундаа ут дуун (урт дуу) болон ерөөл магтаалыг аяндаа сурч орхидог бөгөөд жирийн нэгэн залуу настай хүн хүртэл тавь жаран эхэн ут дуу (урт дуу) мэддэг байсан билээ³¹. Ийм үзэгдэл Монголын бусад аймгийн олонход нь тун ховор тохиолддог.

Ойрад болон халимагийн ардын дуунууд нь олон зуун жилийн турш, үе үеийн Ойрад-Халимагийн дуучин нарын ам амаар дамжиж уламжлагдан ирэхдээ зөвхөн амаар дамжин уламжлагдсан төдийгүй, бас бичиг судар дэвтэр

²⁹ Дууны цэг (дууна цег) — энэ нь дууны бадгийг зааж буй. Шинжааны ойрадын ут дууд (урт дуунууд) нь голдуу гурван цэг байдаг. Гэхдээ бас дөрвөн цэг буюу тав, зургаан цэг дуу ч байгаа билээ. Настай хүмүүсийн хэлэхээр ойрад ут дуун (урт дуу) нийт 360 байна гэдэг. Ойрад ноёны зарлигаар цэцэн мэргэн эрийн сайн Эдэг гэдэг нэг хүн бүх ойрад хүмүүс оршин суусан газар нутгийг бүгдийг нь эргэн тойрч барсны хойно нэг өдөр нэг ут дуу (урт дуу) зохиож 360 хоногт 360 эхэн ут дуу (урт дуу) зохиосон гэдэг домог буй. Шинжааны ойрад ут дуун (урт дуу)-ны үг болон аяс нь ерөнхийд нь үзвэл их төлөв адил тал олон буй. Гэхдээ газар газар, овог аймгийн ут дууд (урт дуунууд) нь хоорондоо бас үг болон ая нь газар газар, овог аймгийн хоор хоорондоо их зөрөөтэй байдаг. Жишээлэхэд, Шинжааны Хүр Хар-Усан (Күр Хар-Усн)-ы ут дуу (урт дуу) нь торгуудын ут дуун (урт дуу), өөлдийн ут дуун (урт дуу), захчины ут дуун (урт дуу) хоор хоорондоо их зөрүүтэй. Торгууд нь дотроо бас дахин Вангийн дөрвөн сумны ут дуун (урт дуу) болон Бэйсийн гурван сумны ут дуун (урт дуу) гэж ялгаа буй. Дөрвөн суман хүмүүс дуулахад гурван сумны хүмүүс хараад суухаас өөр аргагүй. Дууны үгс нь ерөнхийдөө их төлөв ойролцоо боловч дууны ая нь адилгүй байдаг. Тэр ч байтугай Вангийн дөрвөн сумны ут дуу (урт дуу) нь мөн дотроо Цагаан усны (уулын) болон Гашуун булгийн (говийн) аяс ч гэж нарийн ялгадаг билээ. Шинжааны бусад газар орны ойрадын ут дуу (урт дуу)-ны байдал нь мөн Хүр Хар-Усантай их төлөв адил, дотроо бас ялгаатай зүйл олон буй.

³⁰ Архи барих ёс — Ойрад хүмүүс зочин гийчдээ архи сөн барих нарийн ёс байдаг. Сөнг дуутай сөн болон дуугүй сөн гэж хоёр хуваадаг. Найр цэнгэл, хурим гийч зэрэг ямар нэгэн ёслолыг гүйцэтгэхдээ урьдаар дуугүй сөн барьж, дараа нь дуутай сөн барьдаг (сөн өргөх, цэнгэл өргөх гэж хэлдэг) ёс буй. Ойрад хүмүүс ут дуу (урт дуу)-гаа дуулж гийч нартаа архи барихдаа тэд өөрийн мэддэг буюу санаанд нь орсон ямар нэгэн дуугаа дураараа дуулан ирсэн зочиндоо архиа барьдаг бус харин найр ёслол эхлэхэд урьдаар ямар дууг дуулах, ямар дууг ямар үед нь дуулах, ямар дууг дуулж аль хүнд барих, дууны хэддүгээр цэг дээр нь барих, найр төгсөхөд ямар дууг дуулах гэх мэт баримтлах хатуу ёс горим байдаг билээ. Шинжааны ойрад хүмүүс дуутай сөн барихдаа (дуутай архи барихдаа) нэгдүгээр цэгийг нь сөгдөн дуулж, хоёрдугаар цэгийг нь босон зогсож дуулаад, дууны хоёрдугаар цэг нь дуусангуут архиа барьдаг ёстой. Архи барихыг дуугүй сөн болон дуутай сөн гэж хоёр хуваадаг. Найр цэнгэл, хурим гийч болон ямар нэгэн ёслолд ирсэн зочиндоо урьдаар дуугүй архи барьж, хойно нь дуутай архи барьдаг юм. Ямар нэгэн ёслол дээр дуу дуулахгүйгээр урьдаар барьсан архийг дуугүй сөн гэж, дуутай архи барьдгийг дуутай сөн гэдэг.

³¹ Настай хүмүүсийн хэлэхээр Шинжааны ойрадын ут дуун (урт дуу) нь 360 байна гэдэг. 1990 оноос өмнө Шинжааны ойрад дотор зарим нэгэн настай хүмүүс нь 200 гаруй ут дуу мэддэг байсан бөгөөд ерийн нэгэн залуу хүмүүс ч жар далан эхэн ут дуу дуулдаг байсан билээ. Харин 1990 оны үеэс эхлэн нийгэм болон хүмүүсийн өдөр тутмын амьдралд тун ч их хувиралт гарч эхэлсэн юм. Ингэснээр угийн ут дуугаа дуулан хэдэн өдөр буюу олон хоногоор үргэлжилдэг хурим нь эдүгээ нэг л өдөр буюу хэдхэн цагаар хийгдэх болсон; угийн өөрийн гэртээ хийж байсан хурим буюу найраа эдүгээ хот балгасны төв дээр хоолны гэрт хийх болсон; уг нь олон хоногоор ут дуугаа дуулан хуримладаг байсан болбол эдүгээ хэдхэн эхэн ут дуу дуулж, нэг хоёрхон ерөөл тавьсны дараа залуу хүмүүс нь орчин цагийн дуу буюу хохир дуу дуулах болсон байдаг. Иймээс залуу хүмүүс явах тутам угийн ут дуу, ерөөл магтаал сурч байсан орчин нь алдагдаж, залуучууд улам улмаар ардын ут дуунаасаа холдсон үзэгдэл тун түгээмэл болсон байна.

дээр тэмдэглэгдэн нэгэн адил уламжлан өвлөгдсөөр ирсэн түүхтэй. Ойрад-Халимагийн ардын дууг багтаасан олон төрлийн аман зохиол нь Орос Халимаг болон Герман, Финланд, Унгар, Дани, Польш, Франц, Чех зэрэг Өрнийн эрдэмтэн судлаачид хийгээд улс үндэстний эрдэмтний анхаарлыг аль эртнээс ихээр татаж байсан ба Ойрад-Халимагийн аман зохиол болон ардын дуунуудыг сурвалжлан цуглуулж, орчуулах, эмхэтгэн хэвлүүлэх ажил XVIII зууны дунд үеэс эхэлсэн байна.

Германы эрдэмтэн Петр Симон Паллас Хаант Орос Улсын Шинжлэх Ухааны Академид уригдан ирж ажиллаж байхдаа XVIII зууны 60-аад онд Халимаг нутгаар хээрийн шинжилгээ хийжээ. Тэрбээр тэндээс хэдэн дуу тэмдэглэж аван түүнийгээ герман хэлээр орчуулж байсан бөгөөд түүнчлэн Халимаг нутагт халимаг хүмүүс товшуур, цуур, ихил, бийв, аман хуур мэтийн зүйл бүрийн хөгжмийн зэмсэг хэрэглэж дуу дуулж, бий биелэж, үлгэр тууль болон «Жангар» хайлж байсан тухай занги чимээг маш нарийнаар тэмдэглэсэн байдаг. Мөн түүнчлэн тухайн үеийн «Гэсэр»-ийн тухай сураг мэдээг бичиж үлдээсэн нь бий [Pallas 1776; Pallas 1881: 150–151].

XVIII–XIX зууны үеийн халимагийн соёл, аман зохиол судалсан нь

XIX зууны эхэн буюу өмнө хагас жилүүдээр Оросын эрдэмтэд буюу жуулчид ч Халимаг нутагт хээрийн шинжилгээ хийж байв. Тухайлбал, 1810 онд Н. Страховын туурвисан «Халимагийн хууль болон хэрэг шүүлт, тэдний сүсэг бишрэлийн арван дүрэм, тарни, сургаалийн зохиол, аман үлгэр, зүйр үг, савардин дуунуудыг хавсарган Халимагийн өнөөгийн байдлыг өгүүлэх нь» [Страхов 1810] гэсэн бүтээл, Н. Нефедьевийн 1834 онд хэвлүүлсэн «Ижил мөрний Халимагуудын талаар газар дээр нь цуглуулсан дэлгэрэнгүй мэдээ» [Нефедьев 1834], 1852 онд П. И. Небольсиний бичсэн «Халимагийн Хошуудын улсын ахуй амьдралын тэмдэглэл» [Небольсин 1852] гэх мэтийн зохиол бүтээлүүдийг дурдаж болох юм. Энэхүү зохиол бүтээлүүд нь голдуу тухайн үеийн халимаг нутгийн ахуй амьдрал, зан үйл, түүх зэргийг бичиж байсны зэрэгцээгээр мөн тухайн нутгийн хүмүүст ардын дуу, аман үлгэр, баатарлаг тууль, дуу хөгжим, бий (биелгээ) зэрэг тархан дэлгэрч байгаа мэдээ занги зэргийг тэмдэглэж байсан байна. Мөн зарим нэгэн зохиолд нь тэдний дуунуудыг ч тэмдэглэсэн зүйл буй. Мөн түүнчлэн 1816 онд Айдарханд³² хэвлэгдсэн «Азийн хөгжмийн сэтгүүл»-д нэлээд хэдэн халимаг дууны үг болон дууны аяыг нь таван эгшигт нотоор тэмдэглэн хэвлэн нийтэлсэн байна [Азиатский журнал 1816]. XIX зууны эхээр Айдарханийн Хөгжмийн сургуулийн багш Иван Добровольский Айдарханийн нутагт амьдардаг олон үндэстэн угсаатны дундаас тэмдэглэж авсан дуу аялгуугаа эмхэтгэж 1816–1818 оны хооронд хэвлүүлж байсан «Азийн хөгжмийн сэтгүүл» гэдэг найман ботидоо оруулан хэвлүүлсэн байдаг. Түүний 1816 оны 11-р сард хэвлүүлсэн анхдугаар ботид нь халимагийн «Маштаг бор», «Сөөм хамартай францис», «Мазан баатар», «Далма баатар» (Дарма баатар?), «Баатар Дарь» (энэ нь Дарь-Эхийг зааж байгаа) гэх таван дуу болон мөн бас «Хав хар моринд» гэх мэт хоёр бий (биелгээ) буюу бүжиг-ийн ая орсон байна. Энэ нь ойрад-халимаг

³² Өдөрхн — Астарханийг халимаг хүмүүс ингэж нэрлэдэг.

дууны аяыг нотоор дэлхий дахинд тэмдэглэсэн анхны зохиол болох бөгөөд тун ч үнэ цэнтэй ажил болсон байна. 1816 онд Айдарханийн «Азийн хөгжмийн сэтгүүл»-д нийтлэгдсэн Халимагийн энэхүү таван дуу болон бийн хоёр аяыг нь С. Г. Рыбаков «Уралын мусульманчуудын ахуйн тухай тэмдэглэл хийгээд тэдний дуу ба хөгжим» [Рыбаков 1897] гэх номондоо тэр хэвээр нь аван хэвлэсэн байдаг.

XIX зууны 50-аад онд Оросын Газарзүйн нийгэмлэгийн эрдэм шинжилгээний ажилтан Н. И. Михайлов Халимагийн Бага цоохор нутагт хүрч шинжилгээний ажил хийж явахдаа тэндээс хэдэн ардын дуу, нэг хэсэг «Жангар»-ын бүлгүүд, зүйр цэцэн үгс болон ойрадын түүхийн холбогдол бүхий ном судрууд цуглуулж авсан байна. Энэхүү ном судрын дотор нь «Халимаг дуу бичдэг дэгтэр — залбирлын дуун» гэсэн дэвтэр байдаг бөгөөд түүнд нь Халимагийн эртний гурван дуу оржээ. Нэг, «Зууд очиж явсан цагийн дуун»³³. Үүнд «Зуу гэдэг газар, зургаан сарын газар гэнэ» гэдэг дуу буй. Хоёр, «Үлдсэн торгууд улсын гаргасан дуун». Үүнд «Баатар Цагаан хаанд баяртай ирж түшсэн билээ» гэдэг дуу буй. Тус дуу нь голдуу Убаши хаан нэг хэсэг харьяатаа аваад Зүүнгар нутаг руугаа явсны хойно хоцорсон хүмүүс Убаши хаанд гомдож дуулсан өнгө аястай буюу агуулгатай байдаг. Гурав, «Үүр залуусын найрын суурийн дуун». Үүнд «Хүрэнгийн жороод, хүзүүн маань сулдана» гэдэг дуу буй. Энэ нь голдуу үүр хань нөхдүүд нэг нэгэндээ үнэнч шудрага байж, хүнд хүчир зүйл тохиолдвол нэг нэгэндээ тус болж, аливаа бүхнээ нэг нэгнээсээ хайрлахгүй байх санааг илтгэсэн утга агуулгатай байгаа билээ.

Энэ цагаас хойш, Ойрад-Халимагийн аман зохиол болон ардын дуунуудын эх хэрэглэгдэхүүнийг цуглуулж тэмдэглэх, орчуулах, эрдэм шинжилгээний үүднээс тэмдэглэн нийтлүүлж олны хүртээл болгох ажилд Иван Добровольский, Габор Балинт, А. М. Позднеев, С. Г. Рыбаков, Ш. Саджирхаев, Э. Джабдыков, Г. Й. Рамстедт, А. М. Листопадов, А. Д. Руднев, Б. Я. Владимирцов, В. Л. Котвич, А. В. Бурдуков, Очирын Номт (Очра Номт), Номынханы Цэрэндорж (Номинхана Церндорж), Х. Хаслунд, М. Тритуз, Палтаан Ниржидмаа, М. Грачева, Жимбийн Бэмбээ (Жимбин Бембэ), Н. Ц. Эрендженев, К. Н. Яцковская, П. Чонкушов, Н. К. Волькович, Сангажийн Бося (Саңһжин Бося), Е. Буджалов (Буджала Е.), Окна Борис, Л. И. Цебигов, Н. Ц. Биткеев, Т. Г. Борджанова (Басангова), Е. Э. Хабунова, Б. В. Шивлянова, Б. Х. Борлыкова, Б. М. Коваева зэрэг эрдэмтэн судлаачид чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Халимаг Ойрад ардын дууг Халимаг нутгаас бичиж авах ажил XVIII зууны дунд үед эхэлсэн бөгөөд эдүгээ нэгэнт 250 гаруй жил болсон байна. Энэхүү хугацаанд Ойрад-Халимагийн ардын дууг Орос болон Өрнө дахинд ном дэвтрээр, мөн бас сонин сэтгүүл дээр ч тун олныг хэвлэн нийтэлсээр ирсэн бөлгөө.

Халимаг Ойрадын аман зохиол болон ардын дуунуудыг XVIII зууны дундаас эхлэн цуглуулах, тэмдэглэх, орчуулах, хэвлүүлэх ажилд Орос болон Германы эрдэмтэд асар их хувь нэмрээ оруулсаар ирсэн билээ. Гэхдээ Халимаг Ойрадын аман зохиолын олон төрөл болон ардын дууг цуглуулах, тэмдэглэх ажилд Унгарын монгол хэл судлаач, нэрт эрдэмтэн Габор Балинт

³³ Зууд очиж явсан цагийн дуун — Ойрад-Халимаг хүмүүс Лхасыг Зуу гэж нэрлэдэг. Энэ нь Лхаст очиж явсан үеийн дуу гэсэн утга бүхий үг. Эрт дээр үед Ойрад-Халимаг хүмүүс Лхаст мөргөл хийхээр явахдаа буюу явах замдаа зохиож дуулсан дуунууд болно.

ч тун их хувь нэмэр өргөсөн хүний нэг билээ. Тэрбээр 1872 оны эцэс болон 1873 оны эхээр монгол хэл судлах зорилгоор Оросын Халимаг нутагт хээрийн шинжилгээний хэдэн сарын аялал хийсэн байна. Тэр урьдаар Казанийн Их Сургуульд очиж, тэнд суралцаж багшилж байгаа халимаг багш оюутнуудыг сурвалжлан, дахин Халимаг нутагт хүрэн хэдэн сар хээрийн шинжилгээ хийж нэлээд олон судалгааны эх хэрэглэгдэхүүн олсон бөгөөд энэхүү эх хэрэглэгдэхүүндээ халимагуудын өдөр тутмын ярианы материалаас гадна халимагуудын тухайн цаг үед гүйцэтгэж байсан зүйл бүрийн зан үйл болон аман зохиолын эх хэрэглэгдэхүүнийг эрдэм шинжилгээний латин галиг үсгээр тэмдэглэж авсан байна. Тэрхүү материал нь 140 гаруй жил Унгарын Шинжлэх Ухааны Академийн архивт хадгалагдсаар ирсэн бөгөөд 2011 онд Унгарын ШУА болон Оросын ШУА-ийн Халимаг Соёл Тууж Шинжилгээний Хүрээлэн хамтран гэрэл зургаар буулган «XIX зууны дунд үеийн Халимагийн зан үйл хийгээд ардын соёл» [Birtalan 2011] гэх нэрээр Будапешт хотод хэвлүүлж олны хүртээл болгосон байна. Тус эмхэтгэлд Габор Балинтын Халимаг нутгаас цуглуулсан зан үйлийн элдэв зүйлийн материалаас гадна ерөөл, үлгүүр, тайллагатай тууль (тээллхтэ тууль / тээлвртэ тууль)³⁴, ут тууль, ардын дуу зэрэг халимаг ардын аман зохиолын олон төрөл зүйлийн эх хэрэглэгдэхүүн орсон байна. Энэ эмхэтгэлд орж буй аман яриа, аман зохиол болон зан үйлийн эх хэрэглэгдэхүүнийг нь Унгарын Роланд Их Сургуулийн багш, эрдэмтэн Агнеш Бирталан англи хэлэнд орчуулсны хамт түүндээ 1200 шахам тайлбар үйлдэж өгсөн нь эрдэм шинжилгээний асар үнэ цэнтэй ажил болсон юм. Тус номонд Габор Балинтын эрдэм шинжилгээний галигаар тэмдэглэсэн «Хуц хамартай бор нь», «Дэлдэн чихтэй хээр нь», «Нарийн голын урсгал нь», «Номхон бор морин чинь», «Эргэж цохиж аашинаа» (энэ нь Эргэж цохиж айсуу гэсэн утга бүхий үг), «Сайхан зээрд морин минь», «Захын гурван гэрүүдэд», «Бугаальг бугаальг борыгоон унана», «Саяг сайхан саарал нь», «Барим иштэй (эштэй) ханжаал чинь», «Чийгт ургасан шалууг», «Гурван саарал морин нь» (хошууд ноён Түмэн Цэрэнжавын өнгөрсөн цагт гаргасан дуун), «Манц гэдэг гол нь», «Сээр дээр нь гархнаа (гарвал)», «Сихиртэй нуурын хөвөөд», «Бухшаа зайсан Муучкааг» (Бухша зээсн Муучкаг) гэх мэт ардын дуу орсон байна. Гэхдээ Габор Балинт энэ 16 дууны гарчигийг нь тавьсангүй харин зөвхөн тоо тавин хэддүгээр дуу гэж тэмдэглэсэн байв. Үнэнийг нь хэлэхэд Ойрад-Халимагууд нь ут дууны (урт дууны) нэгдүгээр цэг (бадгийг зааж буй)-ийн нэгдүгээр мөрийн үгээр дуугаа нэрлэдэг заншилтай билээ.

Эрдэмтэн А. М. Позднеев Ойрад-Халимагийн тулгуур бичиг, түүх болон ардын дуу, аман зохиолын олон төрөл зүйлийг цуглуулж хэвлүүлэх, орчуулах, судлах талаар гарамгай амжилт гаргасан эрдэмтний нэг юм. Тэрбээр 1881 онд «Монгол туургатны ардын дууны яруу найргийн жишээ» гэсэн сэдвээр магистрын зэрэг хамгаалж, «Эрдэнийн эрхи» хэмээх зохиолоороо 1883 онд хэл бичгийн ухааны докторын зэрэг хамгаалсан билээ. «Монгол туургатны ардын

³⁴ Тайллагатай тууль (тээллхтэ тууль / тээлвртэ тууль) — энд оньсогыг зааж буй. Тууль гэдэг үг нь ер нь Шинжааны ойруудад болон ОХУ-ын халимаг хүмүүст хоёр зүйлийн утга буй. Нэг нь домог үлгэр болон домгийг багтаасан бүх үргэлжилсэн үгийн аман үлгэрийг нэрлэдэг. Нэн тодруулж хэлэхэд хүрвэл ахар тууль, тайллагатай тууль, тайлбартай тууль гэж оньсогыг нэрлэдэг. Урт тууль (ут тууль) гэж домог үлгэр, домгийг багтаасан үргэлжилсэн үгээр хэлэгдэх аман үлгэрүүдийг нэрлэдэг.

дууны яруу найргийн жишээ» гэсэн судалгаандаа халх, өөлд, буриадын ардын дууг судалсан бөгөөд энэ нь Ойрад-Халимаг ардын дууг системтэй судалсан нэлээд дорвитой анхны судалгаа болсон байна. Тэрбээр монгол уран зохиол, түүний дотроо монгол ардын дууны төрлийг судалсан Оросын эрдэмтний анхны судлагч нь байснаар үл барам мөн дэлхий дахинд монгол, Ойрад-Халимаг дуу судалсан анхны эрдэмтний нэг нь байсан билээ. Эрдэмтэн А. М. Позднеев Петербургийн Их Сургуулийн Дорно дахины салбарын даалгавраар олон удаа Халимагаар явж эрдэм шинжилгээний хээрийн шинжилгээ хийсэн байна. Ингэж явахдаа цуглуулсан эх хэрэглэгдэхүүнээ эмхэтгэж 1880–1915 оны хооронд олон ном болгон хэвлүүлжээ. Тэрбээр 1892 онд «Халимаг үндэстний сургуулийн ахлах ангийнханд зориулсан халимаг хэлний унших бичиг» хэмээх номоо чулуун бараар тод үсгээр хэвлүүлсэн юм [*Калмыцкая хрестоматия* 1912]. Тус эмхэтгэл нь 1907 болон 1915 онд дахин хоёр удаа хэвлэгдсэн билээ. Тэрбээр мөн «Жангар»-ын гурван бүлгээ «Халимаг аман найраглал — Жангар» [*Джангар* 1911] гэсэн нэрээр чулуун бараар тод үсгээр Петербург хотод 1911 онд хэвлүүлж байв. Түүний «Монгол туургатны ардын дууны яруу найргийн жишээ» [*Позднеев* 1880] гэх бүтээлд нь нийт 65 монгол дуу багтсаны дотор 25 нь халх, 11 нь өөлд (ойрад), 29 нь буриад дуу байв. Тэрбээр 65 дууны шүлгээ эрдэм шинжилгээний үсгээр галиглан, монгол, буриад дууг нь монгол үсгээр, ойрад дууг нь тод үсгээр тэмдэглэсний хамт мөн бас орос хэлээр орчуулан дэлгэрэнгүй тайлбар хийжээ. Эрдэмтэн А. М. Позднеевийн тэмдэглэсэн өөлд дуугаа 11 дуу гэж бичсэн байдаг³⁵. А. М. Позднеевийн тод үсгээр тэмдэглэсэн энэхүү есөн өөлд дуу нь гэвэл «Усны эхэнд хонхолзуур» (Галдамаа баатарын тухай дуу), «Тэр уулын оройд мандсан чиг (ч) наран», «Хангай ханы шилд», «Хутагт лам нар ноёд», «Шангагийн өндөр ууланд» (Шангигин өндр уулд), «Өндөр богдын ард», «Бурхан шашин огторгуй», «Алтан арлын амт нь сайхан» гэх мэт дуунууд болох юм.

Финландын эрдэмтэн Г. Й. Рамстедт болбоос нэрт алтай хэл судлаач, алдарт монголч эрдэмтэн билээ. Тэрбээр алтай төрөл хэл болон монгол хэл судалж асар их амжилтанд хүрсээр үл барам мөн бас монгол, Ойрад-Халимагийн аман зохиолыг эрдэм шинжилгээний үүднээс цуглуулан тэмдэглэх, орчуулах болон хэвлүүлэх ажил үйлсэд ч оюун чадлаа шавхаж, тун ч чармайлттай ажиллаж ирсэн хүн байсан бөлгөө. Эрдэмтэн Г. Й. Рамстедт XIX зууны сүүл болон XX зууны эхээр дорно этгээдэд долоон удаа аялаж эрдэм шинжилгээний хээрийн шинжилгээ хийсэн байв. Тэрбээр 1898, 1909, 1912 онд Монгол улсаар гурван удаа, 1903–1904 онд Оросын Халимаг нутгаар нэг удаа, 1902 онд Афганистаны моголоор нэг болон Шинжааны ойрад хүмүүс суурьшин суусан газар орноор 1905 онд нэг удаа хүрч хээрийн шинжилгээ хийсэн байна. Түүний Монгол улсаас цуглуулсан баялаг их эх хэрэглэгдэхүүнийг Хельсинк Их Сургуулийн багш Харри Халенээс эмхэтгэн эрдэм шинжилгээний олон улсын галиг болон герман орчуулгатай, оршил өгүүлэлтэйгээр 1973 болон 1974 онд хоёр боть болгон «Умард Монголын ардын аман зохиол» [*Ramstedt* 1974] гэсэн нэртэйгээр Финланд улсын нийслэл Хельсинк хотод хэвлүүлсэн байна.

³⁵ Гэхдээ бидний үзсэнээр тэрхүү 11 дууны сүүлийн «Өндөр их довон», болон «Буянаар учирсан ...» гэсэн хоёр нь дуу биш харин ойрад хүмүүсийн дотор эдүгээ хүртэл тун өргөн хэлэгддэг ерөөл юм байна. Тус хоёр ерөөлийг эрдэмтэн А. М. Позднеев эндүүрсэн юм уу эсвэл дуу хэмээн буруу ойлгосон шиг байгаа юм.

Тэрбээр 1903–1904 онд Халимагийн тээгээс (талаас, тал нутгаас) цуглуулсан аман үлгэрээ 1909 он болон 1919 онд эрдэм шинжилгээний олон улсын галиг болон герман орчуулгатайгаар Финланд улсын нийслэл Хельсинкт хоёр дэвтэр болгон хэвлүүлсэн юм [[Kalmükische Sprachproben 1909](#)].

Г. Й. Рамстедт 1905 онд Шинжаанд ирж эрдэм шинжилгээний хээрийн шинжилгээ хийхдээ тэр оны хаврын эхэн сараас 12-р сарын сүүл хүртэл Тарвагтай, Хүр Хар-Усан, Үрэмч зэрэг газраар аялсан байна. Тэр хугацаандаа түүний дагагч Аршаа гэдэг хүнээс нэлээд олон баатарлаг тууль, аман үлгэр, ардын дуу болон бусад зүйлийг тэмдэглэж авчээ. Тэр тухайгаа эрдэмтэн Г. Й. Рамстедт маш нарийнаар тэмдэглэсэн байна [[兰司铁著 2014](#); [Ramstedt 1974](#)]. Гэвч тэдгээр эх хэрэглэгдэхүүн нь эдүгээ болтол хэвлэгдээгүй байсаар. Г. Й. Рамстедтын тухайн үед Шинжаанаас цуглуулсан есөн торгууд дууг нь түүний гарын шавь Пенти Аалто эмхэтгэж, эрдэм шинжилгээний галиг үсэг болон герман орчуулгын хамт 1966 онд Хельсинк хотод хэвлүүлжээ [[Ramstedt, Aalto 1965](#)]. Г. Й. Рамстедтын 1903–1904 онд Халимаг нутгаас цуглуулсан 250 үлгүүр (зүйр цэцэн үгийг зааж буй) болон 88 ахар тууль (оньсогыг зааж буй)-ийг нь мөн түүний гарын шавь Пенти Аалто эмхэтгэж 1956 онд эрдэм шинжилгээний латин галиг үсэг болон герман орчуулгын хамт Хельсинк хотод хэвлүүлсэн байна [[Ramstedt, Aalto 1955–1956](#)]. Мөн Пенти Аалто багшийнхаа 1903–1904 онд халимагийн нутгаас цуглуулсан 49 халимаг дууг нь эмхэтгэж, эрдэм шинжилгээний латин галиг үсэг болон герман орчуулгын хамт 1962 онд Хельсинк хотод хэвлүүлжээ [[Ramstedt, Balinov, Aalto 1962](#)]. Тус 49 халимаг дууны өмнө судалгааны дэлгэрэнгүй удиртгал болон хойно нь тайлбар хадаж өгсөн байв. Нэрт эрдэмтэн Г. Й. Рамстедтын цуглуулсан энэхүү олон цуглуулгын эх хэрэглэгдэхүүнүүд нь эдүгээ манай монгол болон Ойрад-Халимагийн үг хэл, аман зохиол судлах тун ч ховор зүйл болж судлагдсаар байгаа билээ.

1902 онд Тең гол (Дон мөрөн)-ын казакуудын аман зохиол, ардын дуу цуглуулагч болон судлагч А. М. Листопадов Тэн голын (Тең холын) халимагуудаас нэг хэсэг ардын дуу цуглуулан тэмдэглэж авчээ. Тэгээд «Денисовский тойргийн Денисовын казак тосгоноос бичиж авсан халимаг ардын дуунууд» гэсэн өгүүллээ бичсэн байна [[Листопадов 1998](#)]. Тэрбээр Оросын олон үндэстний 500 дуу гаргахаар бэлтгэж байжээ. Гэхдээ тэр материалууд нь хэвлэгдэж чадсангүй. Түүний тэр эх хэрэглэгдэхүүнүүд эдүгээ Санкт-Петербургийн Оросын утга зохиолын хүрээлэнгийн архивт хадгалагдаж байна. Энэхүү эх хэрэглэгдэхүүн нь хоёр зүйл юм. Нэг нь дээр хэлж байгаа энэ эх, нөгөө нь В. Л. Котвичийн гэрийн архивт байгаа гараар бичиж авсан эх юм. Гэхдээ энэ хоёр эх хоорондоо бас бага зөрүүтэй. В. Л. Котвичийн гэрийн архивт байгаа эх нь галигаар байхаар үл баран мөн бас орос орчуулгатай. В. Л. Котвич эдгээр эх хэрэглэгдэхүүнээ Санкт-Петербургийн Орос Утга Зохиолын Хүрээлэнд өгсөн байна. Энэхүү В. Л. Котвичийн гэрийн архивт байгаа гар бичмэлийг нь Оросын ШУА-ын Петербургийн Гар бичмэлийн хүрээлэнгийн халимаг дуу хөгжим судлаач В. К. Шивлянова Оросын утга зохиолын хүрээлэнгээс олж тайлбар сэлт, зүүлт үйлдэж 1998 онд хэвлүүлсэн байна. А. М. Листопадовын энэхүү эх хэрэглэгдэхүүнд нь нийт 18 халимаг ардын ут дуун (урт дуу) болон ахар дуун орсон бөгөөд тухайн үед тэр дуунуудыг нь Халимаг сургуулийн багш Далантай Шалбууров (Далнта Шалбууров) гэгч

хүн орос хэлэнд орчуулж өгсөн байна. А. М. Листопадовын 1933 онд мөн Тэн голын (Тең холын) бузав халимагуудаас цуглуулсан бас нэг хэсэг халимаг ардын дуунууд байгаа бөгөөд түүнийг нь 1998 онд хэвлэлдээ оруулаагүй ажээ. Тус 18 дууны дотор «Жангар»-ын магтаал орсноос гадна Шинжаан, Хөхнуур болон Монголын баруун аймгийн ойрадуудын дотор одоо ч хүртэл тун өргөн тархаж байгаа дуунууд ч байна.

Санкт-Петербургийн Их Сургуулийн монгол хэл шинжигч, дуу хөгжим судлагч нэрт эрдэмтэн А. Д. Руднев монгол угсаатны олон овог аймаг болон Ойрад-Халимагийн дуу хөгжим цуглуулж тэмдэглэх, судлах ажил үйлсэд мөн хүч чадлаа гаргаж, тун тодорхой үүрэг гүйцэтгэж ирсэн эрдэмтний нэг байсан билээ. Тэрбээр 1909 онд «Монгол овогтны аялгуу» (Г. Н. Потанины далан насны ойд зориулсан эмхэтгэл) [Руднев 1909] гэх эмхэтгэл дотор монгол угсаатны халх, буриад, ордос, ойрадын дуу аялгууг тэмдэглэн тайлбарласны хамт мөн бас 70 халимаг дуу аялгууг таван эгшигт нотоор тэмдэглэж тайлбар сэлттэй хэвлүүлсэн байдаг. Энэхүү 70 дуу аялгуу дотор нь 46 ардын дуу, 16 бийний ая болон найман шашны ая орсон байв. Эрдэмтэн А. Д. Руднев 1897 он болон 1904 онд Халимаг нутагт хоёр удаа хүрч хээрийн шинжилгээ хийсэн байв. Тэрбээр 1897 онд анх Халимаг нутгаар очихдоо бага дөрвөдийн Тундутов ноёны суугаа Зост гэдэг газар хүрсэн байна. Тэр хугацаандаа ноёны хатан Өлзийт (Өлзэт) болон бусад хүмүүсээс нэлээд хэдэн ардын дуу тэмдэглэж авчээ. 1904 онд тэр хоёр дахь удаадаа Финландын нэрт монголч эрдэмтэн Г. Й. Рамстедтэй хамтдаа очсон байв. А. Д. Руднев энэ удаа халимаг нутгаас дөрвөн ут тууль болон нэлээд хэдэн ардын дуу тэмдэглэж авчээ. Хоёр эрдэмтэн халимаг нутагт хээрийн шинжилгээ хийж байх энэ хугацаанд нь Санкт-Петербург, Москва зэрэг газрын их сургуульд суралцаж байгаа оюутан Санжи Баянов, Очирын Номт, Манжийн Дорж, Эренжен Хара-Даван сургуулийн амралтаараа нутагтаа ирж амарч байсан тул тэр хоёр эрдэмтний эрдэм шинжилгээнд нь их дэм тус болсон байна. Эрдэмтэн А. Д. Руднев хойно нь 1909 онд Санкт-Петербургт Халимагаас цуглуулан тэмдэглэсэн зүйлээ хэвлүүлэхдээ тэр дөрвөн оюутнаа дуудаж тэднээр 1897 он болон 1904 онд цуглуулан тэмдэглэсэн зүйлээ сэргээж авсны хамт бас тэд дөрвөөр нэлээд олон дуу дуулуулж тэмдэглэж авсан байна. Жишээлэхэд, Санжи Баяновоос «Сөөм хамартай францис», «Бичхэн хээр морь нь бийлсэн дуулсан явалтай», «Мазан баатрын тухай дуун», «Бор морь нь тохоотой, бортогтой архи нь ганзаглаатай», «Бэмбын шар», «Саадаг саадаг үхрийг салгаад юунд хулдсан (худалдсан) буй», «Зургаан арслан (орос зоосыг зааж буй)-ы орос госон», «Хөх тэнгисийн долгион нь долгион нь», «Коокуу» зэрэг арван хэдэн дуу дуулуулан тэмдэглэж авсан байв. Манжийн Доржаас «Сөөм хамартай францис», «Мазан баатар», «Тав болсон галзан минь», «Тавар тувар хулсанд зэгсэнд таван л тугалыгаан хариулна», «Хоёр шарга морин», «Төөлөг ногт нь шаргинаа» гэх мэт 20 шахам дуу дуулуулж тэмдэглэж авчээ. Мөн Эренжен Хара-Даван ч «Хаалга», «Хөх тэнгисийн долгионд долгионд», «Хаврын усан цэгээхэн билээ» гэх мэт хэдэн дуу дуулуулан тэмдэглэж авсан байв. Эрдэмтэн Г. Й. Рамстедт халимаг нутгаас 20 гаруй ут тууль (урт тууль) болон нэлээд хэдэн дуу болон бийн ая тэмдэглэж авсан байна. Үүний дотор Эренжен Хара-Даван түүнд хөгжим хөгжимдөж «Хар ланк бишмэд», «Дуун шалааш», «Шаркаа Баркаа» гэх мэт дуу болон бийн аясыг хөгжимдөн дуулж

өгчээ. Бас нэг хэлэх зүйл гэвэл, энэ дөрвөн халимаг оюутны Санжи Баянов болон Манжийн Дорж хоёр болбоос Москва болон Санкт-Петербургт Урлагийн их сургуульд суралцаж байсан оюутан байгаа юм байна.

Дани улсын эрдэмтэн Х. Хаслунд 1928 оны үеэр Шинжаанд хүрч Харшаарын торгуудууд дунд нэг жил суухдаа Харшаарын ойрад ардын дуунаас 60 шахам дуу цуглуулж бичлэг хийж авсан бөгөөд тэрхүү эх хэрэглэгдэхүүн нь эдүгээ хүртэл Дани улсын музейд хадгалагдаж байгаа юм [[Хаслунд 2010](#); [亨宁·哈士纶 1999](#)].

1937 онд Эрээн хавиргын Хүр Хар-Усны Палтаа вангийн охин Ниржидмаа³⁶-гаас өөрийнхөө мэддэг Шинжааны ойрад ардын дунд өргөнөөр тархан дэлгэрсэн 18 хохир дуу (хокр дуун) болон урт дуу (ут дуу)-г тод үсгээр тэмдэглэж³⁷ «Ниржидмаа гүнж — Монголын арван найман дуу шүлэг» [[Nirgidma 1937](#)] гэдэг нэрээр Франц улсад хэвлүүлсэн байна. Уг нь Орос болон Европын эрдэмтдээс Ойрад-Халимаг нутагт ирж аман зохиол, зан үйл болон хэлний материал цуглуулж ойрадын соёлыг дэлхий дахинд танилцуулж байсан бол Ниржидмаа харин өөрийнхөө үндэстний дуу болон соёлоо харийн улс гүрэнд танилцуулж, үндэстнийхээ үсэг бичиг болон франц хэлээр ном дэвтэр болгон харь улс гүрэнд анх удаа хэвлүүлсэн байна. Ниржидмаагийн тус ном харь гадаад улс гүрэнд хэвлэгдсэн явдал нь ойрад-халимаг хүмүүсийн хувьд тун ч их ач холбогдол бүхий ажил болсон юм. Ниржидмаагийн 1937 онд хэвлүүлсэн номыг 2009 онд Оросын ШУА-ын Халимаг Соёл Тууж Шинжилгээний Хүрээлэнгийн ажилтан П. Э. Алексеева франц хэлнээс орос хэлэнд орчуулан «Ниржидмаа гүнж болон Хятад улсын торгуудын дууны эмхэтгэл» гэсэн нэрээр Элст³⁸ хотод хэвлүүлсэн юм [[Алексеева 2009](#)]. Тус эмхэтгэл нь Ниржидмаагийн тод үсгээр тэмдэглэж үлдээсэн 18 дуу байхаас гадна бас түүнийг нь халимаг кирилл үсгээр буулган тэмдэглэсэн байна. Мөн 1933–1934 онд Францад амьдарч байсан Халимагийн зохиолч нараас ноён хүүхэн Ниржидмааг магтан шүлгэлсэн шүлгээс хэд хэд байдаг. Мөн түүнчлэн Америкийн «Жангар» судлаач нэрт эрдэмтэн Борманжийн Арааш (Борманжин Араш), Халимагийн нэрт эрдэмтэн П. Э. Алексеева нараас Эрээн хавиргын Хүр Хар-Усны ван Палтаа болон түүний хүүхэн Ниржидмаагийн тухай бичсэн гурван судалгааны өгүүлэл буй. Бас номын эцэст нь Ниржидмаа болон түүнтэй хамаа бүхий хэд хэдэн зургийг ч дагалдуулсан байна. 1937 онд Ниржидмаагийн Францад хэвлүүлсэн номыг М. Бүжигмаа монгол хэлэнд орчуулж доктор Д. Таяа дэглэж 2014 онд Монгол улсын Улаанбаатар

³⁶ Ниржидмаа — Эрээн хавиргын Хүр Хар-Усны (Эрэн Хэврһин Күр Хар-усна) торгуудчууд Ниржидмааг Шарцоо гэж дууддаг юм.

³⁷ Угийн хэвлэгдсэн эмхэтгэлд нь францад хэвлэгдсэн 18 дууг Ниржидмаа цуглуулсан гэж байдаг юм. Миний үзэхээр энэ нь цуглуулсан бус харин Ниржидмаа өөрийнхөө мэддэг 18 дуугаа тод үсгээр тэмдэглэж тэдгээрийг францаар орчуулан хэвлүүлсэн юм байна.

³⁸ Элст — Оросын холбооны Халимаг улсын нийслэлийг халимаг хүмүүс «Элст» гэж нэрлэдэг юм. Харин оросоор «Элиста» гэдэг билээ. Орос хэлний «Элиста» гэдэг үг нь халимаг хэлний «Элстэй» гэсэн үгнээс ирэлтэй. Монгол улсын эрдэмтэд энэхүү «Элст», «Элстэй» гэдэг үгийг нь монгол халимаг хэлний аялгуугаар нь бус харин орос хэлний «Элиста» гэсэн дуудлагаар нь авч хэрэглэсээр ирсэн юм. Би үзвээс, монгол газрын нэрийг монгол дуудлагаар нь дуудах нь зөвтэй юм. Энэ нь яг Монгол улсын нийслэл Улаанбаатарыг орос хэлэнд «Уланбатор» гэж дуудсантай ямар ч ялгаа алга билээ. Тийм ч учраас Оросын холбооны Халимаг улсын нийслэл Элстийн нэрийг нь «Элст» гэж халимаг монгол аялгуугаар нь дуудах нь таарах юм.

хотод «Тод номын гэрэл төв»-өөс монгол кирилл үсгээр хэвлүүлсэн байна [Ниржидмаа 2014]. Энэхүү номыг доктор Д. Таяа монгол кирилл үсгээс монгол бичигт буулган 2013 онд Өвөр Монголын ардын хэвлэлийн хороогоор хэвлүүлжээ [Ниржидмаа 2013].

XX зууны үед халимагийн ардын аман зохиол судалсан нь

XVIII зууны болон XIX зууны Ойрад-Халимагийн аман зохиолыг сурвалжлан цуглуулах, тэмдэглэх, орчуулах, хэвлүүлэх ажлыг голдуу Орос болон Өрнийн эрдэмтэн судлагчаас гүйцэтгэж байсан бол харин XX зууны эхнээс эхлэн Халимагийн эрдэмтдээс өөрийнхөө аман зохиол, соёлоо сурвалжлан цуглуулах, тэмдэглэх, орчуулах, хэвлүүлэх ажил үйлсэд идэвхийлэн оролцож эрчимтэй ажиллаж эхэлсэн байна. Үүнд: нэрт эрдэмтэн Очирын Номт (Очра Номт), Басангийн Баатар (Баснга Баатр), Номынханы Цэрэндорж (Номинхана Церндорж) зэрэг хүмүүсийг дурдаж болох юм.

XX зууны эхний үед Халимагийн ардын дуу, «Жангар» болон аман зохиолын олон төрлийг сурвалжлан цуглуулах ажилд гарамгай гавьяа зүтгэл үзүүлсэн хүний нэг нь нэрт эрдэмтэн Очра Номт юм. Тэр бол нэрт монголч эрдэмтэн В. Л. Котвичийн гарын шавь байсан бөгөөд Петербургийн Их Сургуулийн Дорно дахины салбарын болон багшийнхаа даалгавраар Халимагийн «Жангар» болон аман зохиолын эх хэрэглэгдэхүүнийг цуглуулан тэмдэглэх, хуучны гар бичмэлийг хайж сурвалжлах зорилгоор Халимаг нутагт хээрийн шинжилгээний ажлаар олон удаа явсан билээ. Тэрбээр 1908 онд Халимагт очиж алдарт жангарч Ээлээгийн Овлаа (Ээлэн Овла)-аар 10 бүлэг «Жангар» хайлуулан, эрдэм шинжилгээний орос галиг үсгээр тэмдэглэж авсан бөгөөд тэрхүү эх хэрэглэгдэхүүнийг түүний багш В. Л. Котвич тод үсэгт буулган, 1910 онд «Тахь Зул хааны үлдэл, Тансаг Бумба хааны ач, Үзэн алдар хааны хөвгүүн, Үеийн өнчин Жангарын арван бүлэг» гэсэн нэрээр Петербург хотод хэвлүүлсэн билээ [Тахь Зул 1910]. Очирын Номт (Очра Номт) Халимагаас эрдэм шинжилгээний галиг үсгээр тэмдэглэж авсан 1908 оны «Жангар» болон 1909–1911 оны хооронд тэмдэглэж авсан аман зохиолын бусад зүйл бүрийн эх хэрэглэгдэхүүн нь эдүгээ Оросын ШУА-ийн Санкт-Петербургийн Дорно Дахины гар бичмэлийн хүрээлэнд хадгалагдаж буй. Оросын ШУА-ийн Халимагийн соёл тууж шинжилгээний хүрээлэнгийн судлагч, шинжлэх ухааны доктор Б. А. Бичеевээс Очирын Номт (Очра Номт)-ын Айдарханийн дөрвөд, торгуудаас 1909–1911 оны хооронд цугуулсан аман зохиолын материалуудыг эмхэтгэж «Мөнх дээж — аман уран үгийн зохиолуудаас» гэсэн нэрээр 2006 онд Элст хотод халимаг кирилл үсгээр хэвлүүлсэн юм [Очиров 2006]. Тус ном нь эрдэм шинжилгээний нэлээд дэлгэрэнгүй удиртгалтай. Мөн аман зохиол нь дотроо дөрвөд, торгуудын гэсэн хоёр ангиас бүрдэж байна. Дөрвөдийн ангид нь 24 ут тууль (аман үлгэрийг зааж буй), 132 үлгүүрүүд (зүйр цэцэн үгсийг зааж буй), 135 тайлбартай туульс (оньсогыг зааж буй) болон 59 ардын дуу оржээ. Торгуудын ангид нь хэдэн ерөөл, хоёр баатарлаг тууль (эпос), 11 ут туулиас (аман үлгэрээс) гадна 22 дуу орсон байна. Эмхэтгэлийн хойно нь ут тууль (урт тууль) болгоны ерөнхий агуулгыг оросоор орчуулсан ба зарим нэгэн түүхийн учрыг маш нарийн тайлбарласан байна. Мөн түүнчлэн дуу болгоны учир утгийг орос хэлээр тун ойлгомжтой тайлбарлаж өгчээ. Бас нэрийн хэлхээс, үгсийн тайлбар толийг үйлдэж өгсөн байв.

Ойрад-Халимагийн хэл, соёл, аман зохиолын судлал болон цуглуулгын ажил үйлсэд асар их хувь нэмрээ өргөсөн, үндэстний соёлд их буянтай ажил үйлдсэн хүний нэг нь нэрт эрдэмтэн Номынханы Цэрэндорж билээ. Тэрбээр XX зууны өмнө буюу дундаар Монгол улсын баруун бүс нутгийн ойрадууд, Шинжааны ойрадууд болон халимаг нутгийн халимаг-ойрад хүмүүсээс аман уламжлал, зан үйл болон хэлний олон эх хэрэглэгдэхүүнийг цугуулсан байна. Номынханы Цэрэндорж болбоос нэрт алтай хэл судлагч бөгөөд Халимаг улсын хамгийн анхны шинжлэх ухааны доктор (Sc.D) юм. Тэрбээр 30-аад оны эхнээс аваад Астархань, Үзбекстан, Хасагстан³⁹, Хакас, Халимаг зэрэг газар орны их дээд сургууль болон судалгааны хүрээлэнгээр багшилж, судалгааны ажил хийсээр ирсэн бөгөөд олон тооны эрдэм шинжилгээний өгүүлэл, ном зохиол хэвлүүлсэн эрдэмтэн юм. Номынханы Цэрэндорж бол герман, англи, орос, хасаг, үзбек, хакас, төвөд, монгол, буриад, халимаг зэрэг олон хэлийг бүрэн төгс чадамгай эзэмшсэн, хэлний их авьяастай нэрт эрдэмтэн байсан билээ.

XX зууны 30-аад оны эхээр Шинжаан мужийн засгийн газраас угийн ЗХУ-ын БНУУ-ын нийслэл Ташкент (одоогийн Үзбекстан улсын нийслэл) дэх Дундад Азийн Их Сургуульд сурагч томилон суралцуулж байжээ. Үүнд тухайн үед Шинжааны ойрад монголын оюутан ч нэлээд хүн суралцаж байсан байна. Эрдэмтэн Номынханы Цэрэндорж тэр хэдийгээр Шинжааны ойрад нутагт биеэрээ очиж ойрадын аман зохиол, зан үйл болон хэлний эх хэрэглэгдэхүүнүүдийг цуглуулж чадаагүй боловч, тухайн үед тэнд суралцаж байсан Шинжааны ойрад монголын оюутныг сурвалжлан Шинжааны ойрадын тухай нэлээд олон хэрэглэгдэхүүнүүдийг цуглуулж авсан байна. Жишээлбэл, 1935 оны 3-р сараас 1937 оны 4-р сар хүртэл Харшаарын торгууд аймгийн Досаан, Бадмараа болон Эрэн хавиргын Хүр Хар-Усны торгууд аймгийн Мөнхжаргал нараас Шинжааны ойрадын зүйл бүрийн зан үйл, хүмүүсийн нэр, ан агуурсны нэрс, жигүүртэн шувуудын нэрс, өвс модны нэрс болон ойрадын 10 эхэн дуу, 66 оньсогыг тэмдэглэж авчээ. Тэрхүү материал нь эдүгээ Оросын ШУА-ын Халимагийн Соёл тууж шинжилгээний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний архивт хадгалагдаж байна [[Хорьдугаар зууны Халимагийн 2005](#)]. Тэрбээр мөн 1935 онд Ташкент хотод «Монгол хэлний үсгүүд сурах болон унших дэвтэр» гэсэн номоо тод үсгээр хэвлүүлсэн байна [[Номинханов 1935](#)]. Тэрхүү дэвтэр нь тод үсэг сурахад зориулсан боловч түүнд «Арслан туулай хоёрын тууж», «Таван төө сахалтай нэг төө биетэй өвгөн», «Худалч хөвгүүн» гэх мэтийн халимаг аман үлгэрүүд орсны хамт шинжааны ойрад урт дуунаас «Эрэвгэр дэлтэй бор», «Тахтай тарган хулан», «Уужим сайхан булганы хангай», «Гэмпил уулын орой дээр», «Хөх бороон унаад гарлаа», «Нарийн говийн зээрд» гэх мэт зургаан дуу оржээ. Тус зургаан дууг эрдэмтэн А. В. Бадмаев 1971 онд хэвлүүлсэн «Тод бичгийг өөрөө сурах дадлагын ном» гэдэг номондоо оруулж хэвлэсэн байна [[Бадмаев 1971](#)]. Мөн эрдэмтэн Номынханы Цэрэндорж

³⁹ Хасагстан — Казахстаныг зааж буй. Хасагийг орос хэлэнд «казах» гэдэг. Энэ үндэстнийг манай монголчууд эртнээс «хасаг» хэмээн нэрлэсээр ирсэн түүхтэй. Эдүгээ манай сонин сэтгүүл, радио нэвтрүүлэг болон зарим нэгэн ном зохиолд монголчуудын хэрэглэсээр ирсэн «хасаг» гэдэг нэр нэрийдлэг, нэр томъёогоор бус харин орос хэлний «казах» гэдэг үгийг хэрэглэх болсон нь тун ч инээдэмтэй санагдах юм. Үнэнийг нь хэлбэл Дон мөрний хавиар амьдарч байгаа хүмүүсийг «казак» гэж, харин манай Шинжааны хажууд оршдог оросоор «казах» гэдэг үндэстнийг нь «хасаг» гэвэл зохистой билээ.

Петербургийн Их Сургуульд оюутнаар суралцаж байх үедээ 1924 оны 10-р сараас 1925 оны 4-р сард Монгол улсад очиж Монгол улсын баруун бүс нутаг болох Увс аймагт хүрч хээрийн шинжилгээ хийхдээ тэндэхийн дөрвөд, баяд хүмүүсээс ойрадын аман зохиол, ардын билиг зүй, зан үйл болон хэл аялгууны холбогдол бүхий асар баялаг эх хэрэглэгдэхүүнийг цуглуулсан байдаг. Тухайн үед тэмдэглэн үлдээсэн 10 дэвтэр гар бичмэл эх нь эдүгээ Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн архивт хадгалагдаж байгаа бөгөөд түүнд нь дөрвөд, баядын аман үлгэр, баатарлаг тууль, ардын дуу, ерөөл магтаал болон зүйр цэцэн үг гэх мэтийн олон зүйл байдаг. Энэхүү 10 дэвтэр гар бичмэл эхийн найман дэвтрийг нь эрдэмтэн Ж. Цолоо, Э. Пүрэвжав нар гэрэл зургаар буулгаж «Баруун монголын дөрвөдийн зан үйлийн аман зохиолоос» (нэгдүгээр боть) [Номинхана 2008], «Бурхан хааны хөвүүн балчир Бум-Эрдэнэ» (хоёрдугаар боть) [Номинхана 2009a], «Ойрад аман зохиолын сан хөмрөгөөс» (гуравдугаар боть) [Номинхана 2009b] гэсэн номнуудыг удиртгал, тайлбарын хамт хэвлүүлэн гаргаж олны хүртээл болгосон билээ. Мөн тэрхүү Номынханы Цэрэндоржийн цуглуулсан 10 дэвтэр гар бичмэлийг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн багш, эрдэмтэн На. Сүхбаатар болон Т. Ганцогт монгол кирилл үсэгт буулгаж «Ц.-Д. Номинхановын 1924–1925 онд Баруун монголд хийсэн судалгаа» гэсэн нэрээр 2016 онд хоёр боть болгон хэвлүүлсэн байна [Номинхановын 2016]. Хэл бичгийн шинжлэх ухааны доктор Номынханы Цэрэндорж халимаг нутаг болон Тенгийн халимаг ардын урлагчдаас олон ардын дуу цуглуулсан бөгөөд тэр эх хэрэглэгдэхүүн нь эдүгээ болтол хэвлэгдээгүй архивт хадгалагдсаар байгаа юм. Жишээлэхэд, 1962 онд хэлмэрч Манжийн Санж гэдэг нэг л хүнээс 70 хэдэн дууг тэмдэглэж авсан байдаг.

Ойрад-Халимаг болон Монголын түүх, хэл, тулгуур бичиг, аман зохиолыг цуглуулан тэмдэглэх, судлах талаар үлэмж хувь нэмэр оруулсан хүний нэг нь бол алдарт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов юм. Тэрбээр «Монголын нийгмийн байгуулал» [Владимирцов 1934], «Монгол бичгийн хэлийг халхын аялгуутай харьцуулсан хэлзүй. Удиртгал болон авианзүй» [Владимирцов 1929], «Панчатантраас авсан монгол үлгэрийн цоморлиг» [Владимирцов 1918], «Монгол ойрадын баатарлаг тууль» [Владимирцов 1923a] гэх мэт номуудыг хэвлүүлсэн билээ. Мөн 1923 онд Б. Я. Владимирцов тод үсгээс орос хэлэнд орчуулан 24 цуврал үлгэр бүхий «Шидэт хүүрийн үлгэр»-ийг Москва хотод хэвлүүлсэн бөгөөд 1958 онд дахин хэвлэжээ [Владимирцов 1923b].

1962 онд Э. Г. Манжиеваас энэхүү «Шидэт хүүрийн үлгэр»-ийн 24 үлгэрийг халимаг хэлэнд орчуулан «Үхсэн цогцын хувилгаан — Монгол ойрадын туульс» гэсэн нэрээр халимаг кирилл үсгээр Элст хотод хэвлэсэн байна [Үхсэн цогцын хувилгн 1962]. Б. Я. Владимирцов XX зууны эхээр Монгол улсын баруун нутгийн ойрад хүмүүсийн дотор эрдэм шинжилгээ хийж хэдэн жил суухдаа баяд, дөрвөд, урианхай, мянгад зэрэг овог аймгуудаас нэлээд олон аман зохиолын эх хэрэглэгдэхүүн цуглуулсан бөгөөд тэрхүү эх хэрэглэгдэхүүндээ тулгуурлаж «Монгол ардын аман зохиолын жишээ» (баруун хойд монгол) гэсэн номоо 1926 онд Ленинград хотод орос маягийн эрдэм шинжилгээний галиг үсгээр хэвлүүлсэн юм [Владимирцов 1926]. Тус эх хэрэглэгдэхүүн дотор 22 аман үлгэр, нэг бүлэг «Жангар», 17 ерөөл, дөрвөн баатарлаг тууль болон 118

дуу орсон байв. Тус ном нь 1970 онд Англид гэрэл зургаар буулгагдаж дахин хэвлэгджээ. 2005 онд Оросын ШУА-ын «Дорнын утга зохиол» хэвлэлийн газраас «Монгол хэл шинжилгээний бүтээлүүд» гэсэн нэртэйгээр Москва хотод бас дахин хэвлэсэн байна [Владимирцов 2005].

Чех улсад ажиллаж амьдарч байсан Халимагийн эрдэмтдээс халимагийн соёл түүхийн томоохон чуулган болох «Хонх-Халимагийн дээж бичиг» гэсэн таван боть номыг тод үсгээр 1925–1927 онд хэвлэжээ. Үүний эхний хоёр боть нь аман зохиолын холбогдол бүхий зүйлс олон бөгөөд гуравдугаар ботид нь ойрад болон Монголын эртний түүх, уран зохиол, тулгуур бичиг болон Төвд, Энэтхэгээс орчуулсан аман үлгэр, зүйр цэцэн үгс зэрэг зүйлс орсон байв [Хонхо 1925–1927]. Жишээлбэл, «Монголын Убаши хун тайжийг цэрэгтэй нь Дөрвөн ойрад дарсан тууж», «Чингис хаан дүү нар болон хөвүүдээ сурган зарлиг болсон нь», «Чингис хаан яаж түшмэлүүдээ магтдаг бүлэг», «Зүүнгарын нутаг яаж тогтсон нь», «Зая бандида» зэрэг бурхан шашны холбогдол бүхий уран зохиол нэлээд буй. Мөн «Шидэт хүүрийн тууль» гэх 12 цуврал үлгэр буй бөгөөд төвд хэлнээс орчуулсан үлгэрүүд (зүйр цэцэн үгс) ч буй. Дөрөвдүгээр ботид нь голдуу орос зохиолчдын зохион бүтээсэн уран зохиолоос халимаг хэлээр орчуулж тод үсгээр хэвлүүлсэн алдарт зохиолууд байгаа юм. Тавдугаар ботид нь голдуу ойрадын түүхийн холбогдол бүхий зүйлс орсон байна. Өмнөх хоёр ботид нь «Жангар», «Гэсэр»-ээс гадна бас 60 хэдэн ут тууль (аман үлгэрийг зааж буй) орсон байна. Үүнээс гадна мөн бас 42 үлгүүр (зүйр цэцэн үгийг зааж буй), 44 ахар тууль (оньсогыг зааж буй) болон 46 ардын дуу ч орсон байдаг. Энэ эх хэрэглэгдэхүүн нь тухайн үеийн халимаг хэл сурах буюу халимаг аман үлгэр, «Жангар», «Гэсэр» болон ардын дуу судлах чухал гарын авлага болж байв.

Эрдэмтэн М. Тритузын цуглуулан бичсэн 27 дуу бүхий «Халимаг дуу — Халимаг дууны хураангуй» гэдэг эмхэтгэл 1934 онд Москва хотод латин үсгээр хэвлэгдсэн байна [Сборник песен 1934]. Тус дууны эмхэтгэлд орчуулсан дуун, зохиолын дуун болон ардын дуунууд орсон бөгөөд дуу болгоны аяыг таван эгшиг бүхий дууны нотоор тэмдэглэж өгсөн байна.

Халимаг нутагт хэвлэгдсэн аман зохиолын ном дэвтэрийн тухай

Халимаг нутагт XX зууны 20, 30-аад оны үеэр нэг үе латин галиг үсэг бичиг хэрэглэж байгаад 40-өөд онд эдүгээ хэрэглэж байгаа халимаг кирилл үсэг авсан билээ. Тийм ч учраас 20, 30-аад онд хэвлэгдсэн зарим нэгэн ном эмхэтгэл нь латин галиг үсгээр хэвлэгдэж байжээ. Тэд тэрхүү үсэг бичгээ шинэ халимаг үсэг гэж нэрлэдэг байв.

Халимаг нутагт олон жилийн турш хэвлэгдсэн ном дэвтэр дотроос хамгийн алдартай нь 1941 онд хэвлэгдсэн «Халимаг фольклор» юм [Хальмг фольклор 1941]. Энэ нь халимаг эрдэмтэн судлаачид нарын 1928, 1933 болон 1936 онд Халимаг нутаг дээр хийсэн хээрийн шинжилгээний материал болон 1935 онд Элст хотод болсон ардын авьяастны уралдаан тэмцээний үеэр тэднээс тэмдэглэж авсан аман зохиолын хэрэглэгдэхүүнд тулгуурласан байна. Тус номыг эрдэмтэн Лэжийн Цэрэн (Лежин Церн), Шалвуурын Гарай (Шалвурин Гарэ) нар эрхлэн хэвлүүлжээ. Үүнд 50 ут тууль (аман үлгэрийг зааж буй), эпос (баатарлаг тууль гэсэн утга бүхий орос үг)-т нь найман бүлэг «Жангар», гурван

ерөөл, 165 тайлбартай туульс (оньсогыг зааж буй), 88 үлгүүр (зүйр цэцэн үгийг зааж буй), хоёр дом шившлэгийн үгс зэрэг аман зохиолын төрөл зүйлийг багтаасан томоохон бүтээл болсон байна. Мөн энэхүү эмхэтгэлд 71 ардын дуу орсон бөгөөд тэдгээрийг долоон хэсэгт хуваасан байна. Энэ нь: Нэг, «Түүхийн дуу»⁴⁰, үүнд нь долоон дуу оржээ. Хоёр, «Салдас дууд»⁴¹, үүнд нь есөн дуу оржээ. Гурав, «Хүүхэд улсын зовлонтой цагийн дууд»⁴², түүнд нь 10 дуу оржээ. Дөрөв, «Уянгын дууд», түүнд нь 18 дуу оржээ. Тав, «Зүйл бүрийн дууд», түүнд нь 60-аад дуу оржээ. Зургаа, «Шаваашнууд»⁴³, түүнд нь хоёр дуу оржээ. Долоо, «Зөвлөлтийн цагийн дууд»⁴⁴, түүнд нь 19 дуу тус тус орсон байна.

Тус эмхэтгэлийн хамгийн гол ач холбогдол нь эмхэтгэгчээс олон удаагийн хээрийн шинжилгээгээр олж цуглуулсан аман зохиолоо огт засвар хийлгүйгээр буулгасан, Ойрад-Халимагийн аман зохиолыг шинжлэх ухаанчаар анх удаа маш нарийнаар төрөл зүйл хуваан бичсэн, уг бүтээлд орсон аман зохиол болгоныхоо хэлсэн хүн, түүний төрсөн нас жил, тэмдэглэсэн он сар өдөр, газар орон, тэмдэглэгч гэгч зүйлийг нь тун нарийнаар тушааж өгсөн байна. Ингэж үйлдсэн зүйл нь өнөөдөр хүртэл манай аман зохиолыг яаж цуглуулах, хэрхэн төрөл зүйлд хуваах, цуглуулсан зүйлээ яаж тэмдэглэж, үгсийг яаж тайлбарлах зэрэг аман зохиолын зүйл бүрийн олон асуудлыг шийдвэрлэх буюу үйлдэхэд жишээ болох бодит баримт болсноороо асар их ач холбогдол бүхий ажил болсон юм.

Дэлхийн II дайн болон халимагчуудыг Сибирьт цөлсөн явдал нь Халимагийн ардын дуу, «Жангар» болон бусад аман зохиолыг цуглуулан тэмдэглэх, эмхэтгэх, орчуулах, судлах, хэвлүүлэх ажилд олон жилийн тасалдал болсон билээ. Харин 1957 онд халимагчууд нутагтаа буцан ирснээр Халимагийн ардын дуу болон бусад аман зохиолыг цуглуулах, судлах ажил дахин сэргэж, эрдэмтэн судлаачдаас олон дуучин, жангарч, үлгэрчийг сурвалжлан тэмдэглэх ажил эрчимтэй хийгдэж ирсэн бөгөөд үүний үр дүнд «Сэтгэлийн хүүр» («Седклин күүр», 1960 он), «Халимаг туульс» (Нэг. 1961 он), «Халимаг туульс» (Хоёр. 1968 он), «Халимаг туульс» (Гурав. 1972 он), «Халимаг туульс» (Дөрөв. 1974 он) зэрэг аман үлгэрийн эмхэтгэлүүд; «Дуулаач тээг минь, дуул» (1958 он), «Халимаг эдүгээ болон хуучны дууд» (Дууны хураангуй, 1961 он), «Халимаг хуучны дуун болон эдүгээ цагийн дууд» (1962 он), «Дуулцагтан —

⁴⁰ Түүхийн дууд — түүхэн утгатай дуунуудыг нэрлэнэ. Угийн номонд нь «Историческ дуд» гэж бичсэн байдаг. Түүхийн дууны хэсэгт «Галдамаа», «Убаши хан», «Сөөм хамартай францис», «Мийтар ноён» (Миитр нойн), «Куураа ноён» (Куура нойн) гэх мэт түүхт хэрэг явдал буюу түүхт хүмүүсийн тухай дуунууд орсон байна.

⁴¹ Салдасын дууд (Салдсин дуд) — цэргийн дуунууд буюу цэрэг эрсийн дуунууд гэсэн утга бүхий үг. Ийм дуунуудад голдуу цэрэгт явсан эрс ээж аав, нутаг усаа санан мөрөөдсөн утга бүхий дуунууд ордог.

⁴² Хүүхэн улсын зовлонтой цагийн дуунууд — энэ нь эмэгтэй хүмүүсийн зовлонтой үеийн дуунууд гэсэн утга бүхий үг. Ийм сэдэв бүхий дуунуудад голдуу харьд морьдсон хүүхэн ээж ааваа санан мөрөөдсөн, нутаг усаа хүсэн мөрөөдсөн утгатай дуунууд байдаг билээ.

⁴³ Шаваашнууд (Шавашмуд) — энэ нь зөвхөн Оросын халимаг хүмүүсийн дотор байдаг нэгэн зүйл аман зохиолын онцгой төрөл юм. Хүмүүс энэхүү аман шүлгийг аялан маш хурдан хэлэхэд хүмүүс түүний аяар биелдэг билээ. Зарим нэгэн настай хүмүүс хэлэх нь эртдээ зарим нэгэн жангарч урьдаар «шавааш» хэлсний дараа «Жангар»-аа хайлдаг байсан гэдэг билээ.

⁴⁴ Зөвлөлтийн цагийн дууд — энэ нь Зөвлөлтийн үеийн дуунууд, Зөвлөлтийн цаг үеийн дуунууд гэсэн утга бүхий юм. Угийн эхэд нь «Советск дуд» гэж бичсэн байдаг.

өмнө цагийн болон эдүгээ цагийн халимаг дууд» (1962 он), «Халимаг яруу найргийн цоморлог» (1962 он), «Халимаг дууд — Халимаг дуудын хураангуй» (1977 он) зэрэг дууны эмхэтгэл; «Халимаг баатарлаг тууль — Жангар» (1960 он), «Жангар — Жангарч Басангийн Муухөвүүний (Баснгин Муукөвүнэ) бүлгүүд» (1967 он), «Хошуун улаан, Баатар Жилган, Алиа Шонхор гурвын бүлэг — Халимагийн баатарлаг тууль» (1973 он), «Халимаг баатарлаг тууль» (1973 он), «Халимаг баатарлаг дуулбар — Жангар» (25 бүлгийн текст. Дээд доод боть. 1978 он) зэрэг Жангарын эмхэтгэлүүд болон бусад аман зохиолын ном эмхэтгэлүүд ч олноор хэвлэгдэж эхэлсэн байна.

10-р сарын хувьсгалын 60 жилийн ойн баярт зориулан Жимбийн Бэмбээгээс (Жимбин Бембэгээс) «Дуулаач тээг минь, дуул» (Халимаг дууны хураангуй) гэсэн ном эмхэтгэн халимаг кирилл үсгээр Элст хотод 1958 онд хэвлүүлсэн байна [Дуулич 1958]. Эмхэтгэгчээс түүвэрт орсон дуунуудаа гурван бүлэгт хуваажээ. Манай цагийн аясууд гэсэн нэгдүгээр бүлгээ дотор нь нэг, «Хувьсгалт дууд»⁴⁵, үүнд 10 дуу; хоёр, «Маркс, Ленин, нам, Эв хамт залуучуудын эвлэлийн тухай дуунууд»⁴⁶, үүнд нь 20 дуу; гурав, «Шинэ жаргалын туск (тухай) дууд»⁴⁷, үүнд нь 43 дуу; дөрөв, «Сангийн аж ахуйн жаргалын туск (тухай) дууд»⁴⁸, үүнд нь 18 дуу; тав, «Төрөхөн орон нутгаа харсалтын туск (тухай) дууд»⁴⁹, үүнд нь 19 дуу; зургаа, «Шинэ цагийн уянгын дууд», үүнд нь 12 дуу орсон бөгөөд нэгдүгээр бүлгээ зургаан хэсэгт хуваасан байна. Хоёрдугаар бүлгээ «Орос хэлнээс орчуулсан дууд», түүнд нь найман дуу оржээ. Гуравдугаар бүлгээ «Халимаг хуучин дууд»⁵⁰ гэж хуваасан бөгөөд түүнээ дотор нь нэг, «Туужийн төстэй дууд»⁵¹, үүнд нь 34 дуу; хоёр, «Халимаг хүүхдийн туск (тухай) дууд»⁵², үүнд нь 17 дуу; гурав, «Хуучны уянгат дууд», үүнд нь 22 дуу орсон байна. Дөрөвдүгээр бүлгээ «Шаваашнууд болон домборт хэлдэг дууд»⁵³, үүнд нь 11 дуу оржээ. Тус номонд 214 дуу орсон бөгөөд энэ дууны эмхэтгэл нь эдүгээ хүртэл тун олон дуу оруулсан эмхэтгэл болсоор байна.

Москва хотоос халимаг кирилл үсгээр «Халимагийн эдүгээ цагийн болон хуучны дуунууд» гэсэн 19 дуу бүхий эмхэтгэл 1961 онд хэвлэжээ [Хальмг өдгэ

⁴⁵ Хувьсгалт дууд — хувьсгалт дуунууд гэсэн утга бүхий үг. Угийн номд нь «Революционн дуд» гэж бичиж буй. Тус хэсэгт Зөвлөлт цаг үеийн хувьсгалт дуунууд орсон байна.

⁴⁶ Маркс, Ленин, нам, Эв хамт залуучуудын эвлэлийн тухай дуунууд — угийн эхэд нь «Маркс, Ленин, парти, комсомолын туск дуд» гэж бичиж буй.

⁴⁷ Шинэ жаргалын туск (тухай) дууд — энэ нь жирийн өдөр тутмын амьдралын тухай утга агуулга бүхий дуунуудыг зааж буй.

⁴⁸ Сангийн аж ахуйн жаргалын туск (тухай) дууд — угийн эхэд нь «колхозин жирһлин туск дуд» гэж бичиж байгаа юм.

⁴⁹ Төрөхөн орон нутгаа харсалтын туск (тухай) дууд (Төрскнэн харслһна туск дуд) — эх орон нутгаа харж хамгаалсан тухай агуулгатай дуунууд гэсэн утга бүхий үг.

⁵⁰ Халимаг хуучин дууд — энэ нь халимаг эртний дуунууд, халимагийн ардын дуунууд гэсэн утга бүхий үг.

⁵¹ Туужийн төстэй дууд (Туужин төстэ дуд) — энэ нь түүхийн сэдэв бүхий дуунууд гэсэн утгатай үг.

⁵² Халимаг хүүхдийн туск (тухай) дуунууд (Хальмг күүкдин туск дуд) — энэ нь халимаг эмэгтэй хүмүүсийн тухай дуунууд гэсэн утга бүхий үг. Ийм сэдэв бүхий дуунуудад голдуу харьд мордсон хүүхэн ээж ааваа санан мөрөөдсөн, нутаг усаа хүсэн санасан утгатай дуунууд олон байгаа билээ.

⁵³ Домборт хэлдэг дууд — энэ нь товшуурт оруулан товшуурдан биелдэг дуунууд гэсэн утга бүхий үг. Халимаг хүмүүс товшуурыг *домбор* гэж нэрлэдэг юм.

1961]. Энэхүү дуунуудын аяыг дэглэн эмхэтгэсэн нь Чонкушов Петр, үгсийн нь дэглэн эмхэтгэсэн нь Эрендженов Нарма болох юм. Тус дууны эмхэтгэлийн эхний «Ленин», «Төрөхөний туск (тухай) дуун»⁵⁴, «Колхозин дуун»⁵⁵, «Лагань»⁵⁶ гэсэн дөрвөн дуу нь Ленин болон төрсөн нутгийн сайн сайхан, сангийн аж ахуй болон Лагань нутгаа магтсан дуунууд байгаа бөгөөд бусад 15 дуу нь залуу хүмүүсийн хайр дурлалыг илтгэсэн хайрын дуу байна.

1962 онд Москвагийн «Хөгжмийн зохиолч» гэдэг хэвлэлийн газраас «Халимаг хуучны болон эдүгээ цагийн дуунууд» гэдэг ном хэвлэсэн байна [Хальмг хуучн 1962]. Тус дууны түүвэрт нийт 25 дуу орсон бөгөөд түүний найм нь зохиолын дуу, 17 нь ардын дуу байв. 25 дуугаа халимаг болон орос хоёр хэлээр хэвлүүлсэн мөртөө мөн ч дуу болгон аяыг нь таван эгшигт дууны нотоор хадаж өгсөн байна. Энэ түүврийг М. Грачев боловсруулж, дууны үгсийг М. Лапиров оросоор орчуулсны хамт Бадман Алексей, Эрдэнийн Бадам, Эрэнжээний Нармаа (Эрнжэнэ Нарма), Манжийн Үлэмж зэрэг хүмүүс ч энэхүү түүврийн ажилд идэвхтэй оролцжээ.

«Дуулцгаатан — өмнө цагийн болон эдүгээ цагийн халимаг дуунууд» гэдэг 57 дуутай эмхэтгэл 1962 онд Халимаг улсын хэвлэлийн газраас халимаг кирилл үсгээр Элст хотод хэвлэгджээ [Дуулцхатн 1962]. Тус эмхэтгэлийг Сангажийн Бося цуглуулан дэглэж гаргасан байна. Эмхэтгэгчээс эмхэтгэлд орсон 57 дуугаа таван хэсэгт хуваасан бөгөөд энэ нь нэг, «Ленин, эв хамт нам болон төрөхөндөө нэрийдсэн дуунууд»⁵⁷; хоёр, «Нүүрлэгч нарын туск (тухай) болон шинэ уянгын дуунууд»⁵⁸; гурав, «Өмнө цаг болон эдүгээ цагийн уянгын дуунууд»; дөрөв, «Домборт хэлж биелдэг дуунууд»⁵⁹; тав, «Шаваашнууд» зэрэг болно.

«Халимагийн яруу найргийн цоморлог» гэх эмхэтгэлийг 1962 онд Халимагийн хэл, утга зохиол, түүх судлах хүрээлэнгээс халимаг кирилл үсгээр Элст хотод Халимагийн хэвлэлийн газраас хэвлүүлсэн байдаг [Антология 1962]. Тус эмхэтгэлийг С. К. Каляев, И. М. Мацаков болон Л. С. Сангаев эмхэтгэж хэвлүүлсэн бөгөөд эмхэтгэлд орсон эх хэрэглэгдэхүүн нь аман зохиол болон бичгийн зохиол (бичгийн зохиолч нарын зохион бүтээсэн уран зохиол) гэсэн хоёр ангиас бүрэлдсэн байна. Аман зохиолын ангид нь «Жангар», «Гэсэр» болон магтаал, ерөөл, ардын дуу зэрэг зүйлс оржээ. Аман зохиолын доторх дууны хэсэгт нь 98 дуу орсон бөгөөд энэхүү 98 дуугаа дотор нь бас долоон хэсэгт хуваасан байна. Энэ нь нэг, «Туужийн дуунууд»⁶⁰, үүнд нь 12 дуу; хоёр,

⁵⁴ Төрөхөний туск дуунууд (Төрснэ туск дуд) — төрөлх нутаг, төрсөн нутаг, эх орны тухай дуунууд гэсэн утга бүхий үг.

⁵⁵ Колхозин дуун — хамтралын тухай дуунууд гэсэн утга бүхий үг.

⁵⁶ Лагань — газрын нэр. Энэ нь Халимагийн Хөх тэнгисийн хажууд байгаа нэг хотын нэр. Тэнд голдуу торгууд хүмүүс амьдардаг бөгөөд тэд загас барьдаг. Каспийн тэнгисийг халимаг хүмүүс *Хөх тэнгис* гэдэг.

⁵⁷ Ленин, Эв хамт нам болон төрөхөндөө нэрийдсэн дуунууд — энэ нь Ленин, Эв хамт нам болон эх нутаг, эх орондоо зориулсан дуунууд гэсэн утга бүхий үг.

⁵⁸ Нүүрлэгч нарын туск (тухай) болон шинэ уянгын дуунууд — ажил хөдөлмөртөө идэвхи хүмүүсийн тухай болон орчин цагийн уянгын дуунууд гэсэн утга бүхий үг. Угийн эхэд нь «Нүүрлэгч нарын туск болн шин лирическ дуд» гэж бичиж буй.

⁵⁹ Домборт хэлж биелдэг дуунууд (Домбрт келж биилдг дуд) — энэ нь товшуурт оруулан товшуурдан биелдэг дуунууд гэсэн утга бүхий үг.

⁶⁰ Туужийн дуунууд — энэ нь түүхийн дуунууд гэсэн утга бүхий үг. Түүх гэсэн үгийг халимагт тууж хэмээн нэрлэдэг.

«Авьяас болон хүч хөлсний дуунууд»⁶¹. Үүнд нь 12 дуу; гурав, «Дураны туск (тухай) дуунууд»⁶², үүнд нь 16 дуу; дөрөв, «Гэр мал бололгоны, өрх бүлийн, байдал жаргалын дуунууд»⁶³, үүнд нь 22 дуу; тав, «Дамбаралт болон шог дуунууд»⁶⁴, үүнд нь дөрвөн дуу; зургаа, «Баатар тууж»⁶⁵, үүнд нь 11 дуу; долоо, «Зөвлөлт цагийн дуунууд»⁶⁶, үүнд нь 32 дуу орсон байна.

10-р сарын хувьсгалын 60 жилийн ойд зориулан 1977 онд 118 дуу бүхий «Халимаг дууд — Халимаг дуудын хураангуй» гэсэн дууны эмхэтгэлийг халимаг кирилл үсгээр Халимагийн хэвлэлийн газраас Элст хотод хэвлэжээ [[Хальмг дуд 1977](#)]. Тус эмхэтгэлд орсон дуугаа нэг, «Хувьсгалт болон эх оронч дууд»⁶⁷; хоёр, «Шинэ жаргалын дууд»; гурав, «Эдүгээ цагийн дууд»; дөрөв, «Хуучин цагийн дууд»⁶⁸; тав, «Шаваашнууд» гэсэн таван хэсэгт хуваажээ.

Н. К. Волькович, Н. Ц. Эрендженовын эмхэтгэн найруулсан «Тээгийн аясууд — Халимаг улсын урьдахь болон эдүгээ цагийн дууд» гэсэн дууны эмхэтгэл Халимаг дэгтэр гаргагчаас 1982 онд халимаг кирилл үсгээр Элст хотод хэвлэгдсэн байна [[Теегин айсмуд 1982](#)]. Энэ дууны эмхэтгэлд нийт 70 гаруй дуу орсон бөгөөд дуунуудаа «Халимаг улсын урьдахь цагийн дууд» болон «Эдүгээ цагийн халимаг дууд» гэж хоёр хэсэгт хуваажээ. Мөн түүнчлэн дуу болгоны аяыг таван эгшигт дууны нотоор тэмдэглэсэн байна. Дууны аяыг нь Н. К. Волькович болон П. О. Чонкушов тэмдэглэжээ. Урьдахь цагийн дуунд нь Халимаг Ойрад хүмүүсийн байнга дуулагддаг урт дуу болон хохир дуунууд (ут дуун болн хокр дууд) орсон байна. Эдүгээ цагийн дуунд нь голдуу зохиолын дуу орсон боловч эдүгээ цагийн ардын дуунууд ч байгаа юм.

1987 онд эрдэмтэн Н. Ц. Биткеев «Халимаг ардын дууны яруу найраг» гэсэн судалгааны номоо орос хэлээр Халимагийн хэвлэлийн газраас хэвлүүлжээ [[Биткеев 1987](#)]. Тус бүтээл ерөнхийдөө халимаг ардын дууг судалсан бүтээл боловч хойнох хавсралтын хэсэгт нь 23 ардын дууны аяыг таван эгшигт нотоор тэмдэглэж, халимаг дууны үгсийг нь дагуулж өгсөн байна.

Монгол дуу судлагч эрдэмтэн К. Н. Яцковская 1988 онд «Монгол ардын дуунууд» гэсэн судалгааны ном хэвлүүлжээ [[Яцковская 1988](#)]. Тус зохиол нь дууны судалгаа болон дууны текст гэсэн хоёр ангиас бүрэлдэж байна. Судалгааны ангид нь ардын дуучид, ардын дуу, ардын дууны мотив, дууны дүрслэлийн арга барил болон ардын аман яруу найраг хийгээд орчин үеийн яруу найргийг харьцуулан судалсан ажээ. Тус ном нь судалгаанаас гадна ардын дууны текстүүд, ардын дууны орос орчуулга, ардын дууны хэлхээ,

⁶¹ Авьяас болон хүч хөлсний дуунууд — хөдөлмөрчин түмнийг магтан дуулсан дуунууд гэсэн утга бүхий үг.

⁶² Дураны туск дуунууд (Дурна туск дуд) — энэ нь янаг амрагийн тухай дуунууд, хайр дурлалын тухай дуунууд гэсэн утга бүхий үг.

⁶³ Гэр мал бололгоны, өрх бүлийн байдал жаргалын дуунууд — энэ нь зан үйл, зан заншилтай холбогдол бүхий дуунууд гэсэн утгатай юм.

⁶⁴ Дамбаралт болон шог дуунууд (Дамбрлт болн шог дуд) — энэ нь шогтой буюу хошин шог дуунууд гэсэн утга бүхий үг.

⁶⁵ Баатар тууж — энэ нь зоригтой баатар эрсийн тухай дуунууд гэсэн утга бүхий үг.

⁶⁶ Зөвлөлтийн цагийн дуунууд — угийн эхэд нь «Советин цагин дуд» гэж бичиж буй.

⁶⁷ Хувьсгалт болон эх оронч дууд — угийн эхэд нь «Революционн болн патриотическ дуд» гэж бичиж буй.

⁶⁸ Хуучин цагийн дууд — энэ нь эртний ардын дуунууд гэсэн үг.

сурвалжилсан дуучдын нэрсийн жагсаалт, үгсийн тайлбар болон ном зүй гэх мэт хэсгүүдээр бүрэлдсэн байна. Дууны текст нь зохиогчийн Монгол улсын Ховд болон Увс зэрэг аймгуудаас цуглуулсан 219 ойрад ардын дуу орсон бөгөөд тэрхүү дуунуудаа монгол кирилл үсгээр тэмдэглэсэн байна. Мөн түүнчлэн энэхүү дуунуудаасаа 37 дууг сонгон орос хэлээр орчуулжээ. Судлагчийн хийсэн энэ судалгаа нь нэлээд дорвитой сайн судалгаа болсон бөгөөд хойно дагалдуулсан 219 ардын дуу нь ч монгол ардын дуу судалж байгаа дэлхийн олон эрдэмтдэд тун ч үнэ цэн бүхий эх хэрэглэгдэхүүн болж өгсөн юм.

1989 онд «Төрөхөн газрын дууд — Халимаг улсын хэзээнх болон эдүгээ цагийн дууд» гэдэг ном халимаг кирилл үсгээр Элст хотод Халимаг дэгтэр гаргагчаас хэвлэгдсэн юм [Төрскн хазрин дуд 1989]. Тус номыг эрдэмтэн Окна Борис цуглуулан эмхэтгэж хэвлүүлсэн байна. Энэхүү номонд нийт 216 дуу орсон бөгөөд дуугаа долоон хэсэгт хуваажээ. «Хэзээнх дууд (хуучны цагийн дууд)»⁶⁹-ын хэсэгт нь 81 дуу; «Эх орны болон иргэний дайны цагийн дууд»⁷⁰ нь 16 дуу; «Шинэ жаргалын дууд (шинэ жаргалын туск (тухай) дууд)»⁷¹ нь 45 дуу; «Төрөхөн орон нутгаа харсалганы туск дууд (Төрөхөнөөн харсагч дайны цагийн туск (тухай) дууд)»⁷² нь 18 дууд; «Халимагуудын туулгасны туск (тухай) дууд (Халимагуудыг Сибирь лүү туусны туск (тухай) дууд)»⁷³ нь 7 дуу; «Эдүгээ цагийн дууд (Эдүгээ цагийн туск (тухай) дууд)»⁷⁴ нь 31 дуу; «Домборт бийлэн хэлдэг дууд болон шаваашууд (домборт дуулан биелдэг дууд болон шаваашнууд)»-д нь 18 дуу тус тус орсон байна. Цуглуулан эмхэтгэгч номныхоо өмнө дэлгэрэнгүй судалгааны өгүүлэл бичжээ. Тус дууны эмхэтгэл нь халимаг нутагт эдүгээ хүртэл хамгийн олон дуу орсон дууны түүвэр болсон юм.

Бас нэг дурдах зүйл бол халимагийн эрдэмтэн судлаачид болон багш нараас Халимагийн бага сургууль болон дунд сургуулийн сурагч нарт өөрийн эх хэлээ сурч эзэмших, өөрийн төрөлх хэлний гайхамшигт соёлоо сонирхон ойлгуулах зорилгоор зүйл бүрийн утга зохиолын унших бичгүүд хэвлүүлсээр ирсэн явдал юм. Тухайлбал, «Төрөхөн литератур», «Төрөхөн утга зохиол», «Төрөхөн хэл», «Төрөхөн үг», «Уншилганы дэгтэр», «Хичээлийн хойно уншилганы дэгтэр», «Шонхор», «Цагдаа», «Хараадай» (хараацай гэсэн утга бүхий үг) гэх

⁶⁹ Хэзээнх дууд (хуучны цагийн дууд) — энэ нь эртний дуунууд, эртний ардын дуунууд гэсэн утга бүхий үг.

⁷⁰ Эх орны болон иргэний дайны цагийн дууд — энэ нь эх орон болон иргэний дайны үеийн дуунууд гэсэн утга бүхий үг.

⁷¹ Шинэ жаргалын дууд (шинэ жаргалын туск дуунууд) — энэ нь голдуу жирийн амьдралын тухай сэдэв бүхий дуунууд болно.

⁷² Төрөхөн орон нутгаа харсалганы туск дууд (Төрөхөнөө харсагч дайны цагийн туск дууд) — эх орон, эх нутгаа харж хамгаалсан тухай, эх орон, эх нутгаа харж хамгаалсан дайны үеийн агуулгатай дуунууд гэсэн утга бүхий үг.

⁷³ Халимагуудыг туулгасны туск дууд (Халимагуудыг Сибирь лүү туусны туск дууд) — энэ нь халимагуудыг Сибирь лүү цөлсөн тухай дуунууд гэсэн утга бүхий үг. 1943 оны 12-р сарын 28-ны өдөр бүх халимаг хүмүүсийг нутгаас нь Сибирь лүү цөлж, тэд хойно нь 1957 онд халимаг нутагтаа эргэн буцаж ирсэн гунигт түүхтэй билээ. Энэ дуунууд нь тэднийг Сибирь лүү цөлсөн тухай, тэд Сибирь лүү цөлөгдсөн зам зуураа үзсэн зовлонгийн тухай, мөн бас Сибирьт байсан үеийн зүйл бүрийн хүчир бэрхшээл, зовлонгийн тухай өгүүлсэн агуулга бүхий дуунууд юм.

⁷⁴ Эдүгээ цагийн дууд (Эдүгээ цагийн туск дууд) — энэ нь орчин цагийн дуунууд гэсэн утга бүхий үг.

мэт олон зүйлийн ном дэвтрүүд хэвлэгдэж байна. Эртнээс аван хэвлэгдсээр ирсэн энэхүү олон утга зохиолын зүйл бүрийн унших бичигт аман зохиолын зүйлс зохих хувийг эзэлсэн байдаг. Эдгээр бичгийн номнуудад ч ардын дуунууд олон хэвлэгдсэн билээ. Жишээлэхэд, 1989 онд хэвлэгдсэн долоо, наймдугаар ангийн сурагчдад зориулсан «Төрөсхөн литератур» гэх унших бичигт [[Төрснн литератур 1989](#)] «Жангар»-ын бүлгүүд, аман үлгэр, ерөөлүүд орсноос гадна «Алтай хангайн шил», «Мазан баатар» (Мазн баатр), «Убаши хаан», «Саяг саяг саарал», «Агчийн уулийн бэтэг» гэх мэт 12 халимаг урт дуу (ут дуун) болон хохир дуу (хокр дуун) оржээ. Мөн 1995 онд бага сургуулийн гуравдугаар ангийн сурагчдад зориулж хэвлүүлсэн «Шонхор» гэх номонд [[Шонхор 1995](#)] «Жангар»-ын нэлээд олон бүлэг, урт тууль, ерөөл магтаал, тайлбарт тууль, үлгүүр, «Орчлонгийн гуравт»-аас гадна «Алтай хангайн шил», «Яргай хээр», «Хар хэлэн тогоруун», «Үрийн торгай» (Өрин торһа), «Богшуургас» (Богшурһас — богширгоны олон тоо) гэх мэт халимаг ардын урт болон хохир дуунууд орсон байв. Бас 2012 онд наймдугаар ангийн сурагчдад зориулж хэвлүүлсэн «Төрөсхөн утга зохиол» гэх номонд [[Төрснн утх зокьял 2012](#)] мөн «Жангар», ут тууль, тайлбарт тууль, үлгүүр, ерөөл магтаалууд орсноор үл барам «Сөөм хамартай францис», «Убаши хаан», «Галдамаа» зэргийн дуунууд оржээ. Үүнээс гадна халимаг ардын дуунууд нь бусад хичээлийн дэвтэрт ч мөн нэгэн адил олон орж хэвлэгдсэн байгаа билээ.

1991 онд «Халимаг ардын зуун дуун» гэсэн номыг Л. И. Цыбиков Элст хотод халимаг кирилл үсгээр Халимагийн хэвлэлийн газарт хэвлүүлжээ [[Сто песен 1991](#)]. Тус номонд орсон дуунуудаа дөрвөн хэсэгт хуваасан байна. Үүнд нэг, «Ут дууд (Урт дуунууд)»; хоёр, «Ахар дууд»; гурав, «Домборт хэлдэг дууд»⁷⁵; дөрөв, «Сибирьт гаргасан дууд» зэрэг болно. Энэ дууны өмнө нь судалгааны удиртгал байхаар үл барам эмхэтгэлийн хойно энэхүү 100 дууг аль газар, хэнээс тэмдэглэн авсан, дууг дуулсан хүний овог нэр, газар орон, он жил, хадгалагдаж байгаа нутаг орон зэргийг маш нарийнаар тушааж өгсөн байна. Мөн тус номонд орсон 100 дууныхаа аяыг бүгдийг таван эгшигт дууны нотод оруулсан байна.

Ардын дууч болон хэлмэрч Ц. К. Жаргаеваас 1993 онд «Амьд булаг — Ц. К. Жаргаевагийн аман зохиолын нөөц» гэсэн номыг Элст хотод халимаг кирилл үсгээр хэвлүүлжээ [[Өмд булг 1993](#)]. Тус номонд 30 шахам ерөөл, зургаан ардын дуу болон зан үйлийн холбогдол бүхий олон зүйл орсон байна. Хэвлүүлсэн дуун дотор нь «Өндөр дээр нь гархула», «Зуу гэдэг газар», «Хар хэлэн тогорууд», «Өнөдийн дөрвөн цагт», «Өндөр уулын бэл», «Борыгоон тохиит» (тохооч гэсэн утгатай үг) зэрэг ардын дуунууд орсон байв.

«Хэл өргөжүүлэлгэний дэгтэр» гэдэг аман зохиолын эмхэтгэлийг 1994 онд Элст хотод халимаг кирилл үсгээр Калян Александра хэвлүүлсэн юм [[Кел өргжүүлһнэ дегтр 1994](#)]. Эмхэтгэл нь дунд сургуулийн сурагч нарт уншихад зориулагдсан байна. Гэхдээ энэхүү эмхэтгэл нь Ойрад-Халимагийн аман зохиолын олон төрөл зүйлийг бүгдийг нь хамран оруулсан учраас тун сайн эмхэтгэл болсон хэмээн бид үзэж байгаа билээ. Тус эмхэтгэлд ахар тууль (оньсогыг зааж буй), үлгүүр (зүйр цэцэн үгийг зааж буй), ерөөл магтаал, ардын

⁷⁵ Домборт хэлдэг дуунууд (домбрт келдг дуд) — энэ нь товшуурт оруулан товшуурдан биелдэг дуунууд, товшуур цохин дуулдаг дуунууд гэсэн утга бүхий үг. Мөн ойрад хүмүүс товшуургүй тохиолдолд үгийг нь хэлж дуулж биелдэг нэг хэсэг дуунууд ч буй.

дуун, орчлонгийн гурван болон дөрвөн (ертөнцийн гурав болон дөрөв), ут туулиуд (аман үлгэрүүдийг зааж буй)-аас гадна бас «Жангар»-ын хэдэн бүлэг орсон байна. Олны дууд (олны дуунууд буюу ардын дуунууд гэсэн утга бүхий үг) гэсэн төрлөө дотор нь бас туужийн дууд⁷⁶, авъяасны болон хүч хөлсний дууд⁷⁷, дурын тухай дууд⁷⁸, гэр мал бололгон, өрх бүлийн, байдал жаргалын дууд⁷⁹ хэмээн дөрвөн зүйлд хуваасан бөгөөд нийт 29 дуу оржээ.

1998 онд Халимагийн хэвлэлийн газраас «Халимагийн хуримын зан үйлийн яруу найргийн шинжилгээ болон материалууд» гэсэн ном бүтээлийг Халимагийн Их сургуулийн багш эрдэмтэн Е. Э. Хабунова орос хэлээр Элст хотод хэвлүүлсэн байна [Хабунова 1998]. Тус зохиол нь халимаг хуримын зан үйлийн яруу найргийн шинжилгээ болон хавсралт гэсэн хоёр том ангиар бүрэлдсэн байдаг. Судалгааны ангиа хоёр бүлгээр бичсэн ба нэгдүгээр бүлэг нь халимагийн хуримын зан үйлийн дууны яруу найргийн шинжилгээ, хоёрдугаар бүлэг нь халимагийн хуримын зан үйлийн ерөөл магтаал болон дом шившлэг хийгээд бусад жижиг сажиг аман яруу найргийн шинжилгээ болох юм. Хавсралтын материалын ангид нь ардын дуу, ерөөл магтаал, хэмээлгэн, оньсого болон бусад зүйлс орсон байна. Дууны хэсэгт нь хуримын зан үйлд холбогдол бүхий 93 ардын дуу орсон бөгөөд дуугаа халимаг кирилл үсгээр тэмдэглэжээ.

Ардын дууг судалсан ном дэвтэр, эмхэтгэлүүд хэвлүүлэх уламжлал XXI үеийн эхэнд

2005 онд эрдэмтэн Н. Ц. Биткеев «Халимаг ардын дууны аман зохиол» гэсэн халимаг ардын дууг судалсан нэг сэдэв бүхий эрдэм шинжилгээний номоо Элст хотод хэвлүүлжээ [Биткеев 2005]. Тус номын хавсралтын хэсэгт нь 53 халимаг дуу орсон бөгөөд судлагчаас дуу болгоноо халимаг кирилл үсгээр тэмдэглэсний хамт дууны аяыг нь таван эгшигт нотод оруулж бичиж өгсөн байгаа юм.

Халимагийн ардын аман зохиолыг хөгшдөөс цээжлэн өвлөх, цуглуулах, эмхэтгэх, орчуулах, хэвлүүлэх ажил үйлсэд халимагийн зохиолчдоос бага бус ажил хөдөлмөр хийж ирсэн билээ. Түүний нэг нь халимагийн алдарт зохиолч Калян Санж болох юм. Калян Санж хар багаасаа өөрийн үндэстнийхээ аман зохиол болон соёлдоо тун ч хайртай байжээ. Тэрбээр бага хүүхэд байснаасаа аван өвгөд хөгшдийн хэлдэг зүйл бүрийн аман зохиолыг нэлээд олон цээжилснээр үл барам мөн тэмдэглэж ирсэн байв. Тэрбээр өөрийн цээжилсэн зүйлсээ хүмүүст хэлж байснаар барахгүй мөн сонин сэтгүүлд ч нэлээд олон нийтлүүлж ирсэн билээ. 2005 онд Халимагийн хэвлэлийн хорооноос халимаг

⁷⁶ Туужийн дуунууд (туужин дуд) — түүхийн дуунууд гэсэн утга бүхий.

⁷⁷ Авъяасны болон хүч хөлсний дууд — ийм дуунуудад зүйл бүрийн дуу орсон байна. Үүнд голдуу залуучуудын хайр сэтгэлээ илтгэсэн хайрын дуунууд, дүү нь ахынхаа ач гавьяаг дурсан санасан ахын тухай дуунууд, мөн бас хүмүүсийн ажил хөдөлмөрийн тухай, найр жаргалын тухай гэх мэт олон утга агуулгатай дуунууд байгаа юм байна.

⁷⁸ Дурын туск дуунууд (дурна туск дуд) — хайрын буюу янаг амрагийн дуунууд гэсэн утга бүхий.

⁷⁹ Гэр мал бололгон, өрх бүлийн, байдал жаргалын дууд — зан үйлийн холбогдол бүхий дуунууд гэсэн утга бүхий үг.

кирилл үсгээр «Тээгийн булаг» гэсэн ном Элст хотод хэвлүүлсэн билээ [Калян Санж 2005]. Тус номын зохиогч нь алдартай зохиолч Калян Санж болох юм. Энэхүү ном нь дээд болон доод гэсэн хоёр ангиас бүрэлдсэн байгаа. Дээд анги нь Калян Санжийн зохион бүтээсэн зохиолууд, доод анги нь Калян Санжийн өөрөө мэддэг болон бусдаас тэмдэглэж авсан аман зохиолын зүйл бүрийн хэрэглэгдэхүүн болно. Энэхүү аман зохиолын эх хэрэглэгдэхүүнд нь «цастир», «биеэ буулилган» (бийэн буульһн)⁸⁰, «магтаал», «ерөөл», «муужируулган» (муужрулһн)⁸¹, «хараал», «шаваашнууд (шавашмуд) болон домборт оруулаад хэлдэг дууд», «сөнгийн дуун», «саатуулганы дуун»⁸² гэсэн аман зохиолын олон төрөл зүйл орсноос гадна бас нэлээд олон домог үлгэр, явган үлгэр болон ардын дуу орсон байна. Тэрбээр ардын дуунуудаа «Олон амьтны дууд»⁸³; «Сэтгэлийн тачаалын туск (тухай) дууд»⁸⁴; «Гашуудалтай дууд»⁸⁵; «150 настай дууд»⁸⁶ гэж хэсэгт хуваасан бөгөөд түүнд нь нийт 50 шахам дуу орсон байна. Мөн «цастир», «саатуулганы дуун» (бүүвэйн дуу гэсэн утга бүхий үг) гэсэн хэсэгт нь бас хэд хэдэн дуу оржээ. Түүнээс гадна Калян Санж бас нэлээд олон зохиолын дууны үг бичсэний хамт аяыг нь ч зохиосон байна.

Халимагийн Их Сургуулийн багш, доктор, профессор Е. Э. Хабуновагийн «Голомт — Халимагуудын амьдралын эргэцийн зан үйл болон аман үүдээвэр» гэсэн бүтээлийг Халимаг Улсын Их Сургуулийн Халимаг утга зохиолын тэнхимээс 2005 онд халимаг кирилл үсгээр Элст хотод хэвлэжээ [Хабунова 2005]. Эрдэмтэн Е. Э. Хабуновагийн тус бүтээл нь нүүр үг, ашигласан ном зүй, зургуудаас гадна гол зохиол бүтээлийг нь хоёр их төрөлд хувааж болох юм. Нэгдүгээр төрөл нь таван ангиар бичсэн бөгөөд үүнд нь, Халимаг нутагт халимаг хүмүүсийн төрөхөөс үхэх хүртэлх бүх зан үйл, зан заншлын тухай танилцуулан өгүүлсэн бол хоёрдугаар төрөлд нь аман үүдээвэр гэсэн зүйлс орсон бөгөөд үүнд нь голдуу зан үйл, зан заншилтай холбогдол бүхий ерөөл, магтаал, сургамжийн үг, орчлонгийн гурван болон дөрвөн (ертөнцийн гурав болон дөрөвийг зааж буй), олны дуун (ардын дуу) зэрэг эх хэрэглэгдэхүүн орсон байна. Тус бүтээлийн олны дуун гэсэн хэсэгт «Алтай гэдэг газраас нь», «Алтай дээр нь гархула», «Цастын цагаан уул» гэх мэт 20 дуу орсон байна. Эдгээр дуунууд нь голдуу хурим найр, баяр цэнгэл дээр дуулдаг зан үйлтэй холбогдол бүхий дуунууд юм.

2006 онд Элст хотод «Цэцэн булаг» гэдэг ном халимаг кирилл үсгээр хэвлэгдсэн [Цецн булг 2006]. Тус номыг А. П. Амбекова настан хэвлүүлжээ. А. П. Амбекова настан болбоос ардын ерөөлч, шүлэгч, дуу зохиогч, халимаг ардын зүйл бүрийн уламжлалыг өвлөн залгамжлагч нэрт ардын аман урлагч

⁸⁰ Биеэ буулилган (бийэн буульһн) — биеэ магтсан, урамшуулсан зүйлс гэсэн утга бүхий үг.

⁸¹ Муужируулган (муужрулһн) — бусдыг муушсан, муу хэлсэн зүйл гэсэн утга бүхий үг.

⁸² Саатуулганы дуу (саатулһна туск дун) — бүүвэйн дуу гэсэн утга бүхий үг.

⁸³ Олон амьтны дуунууд (олн амтнэ дуд) — энэ нь ардын дуунууд гэсэн утга бүхий үг.

⁸⁴ Сэтгэлийн тачаалын туск дуунууд (седклин тачалин туск дуд) — энэ нь хайр дурлалын дуунууд, янаг амрагийн дуунууд гэсэн утга бүхий үг.

⁸⁵ Гашуудалтай дуунууд (нашудлта дуд) — энэ нь гунигт дуунууд гэсэн утга бүхий үг.

⁸⁶ 150 настай дуунууд (150 наста дуд) — энэ нь 150 жилийн түүхтэй дуунууд, 150 жил болсон дуунууд гэсэн утга бүхий үг. 1812 оны Орос–Францын дайнд олон халимаг цэрэг маш баатарлагаар байлдаж, дайны агуу их ялалтыг олсон билээ. Тус дуунууд нь тухайн тэр үед үүссэн дуунуудыг зааж байгаа юм.

байсан юм. Тэрбээр алдарт жангарч Ээлээгийн Овлаагийн (Ээлэн Овлан) зээ охин нь байв. Настан уг нь эгч дүү хэд байсан бөгөөд Сибирьт цөлөгдөн очсоны дараа бусад нь нас барж, хойно нь цагаатгагдаж ганцаар халимаг нутагтаа буцаж ирсэн гашуун түүхтэй бөлгөө. Настны хэвлүүлсэн энэхүү номонд түүний хэлсэн зүйл бүрийн ерөөлүүд, үлгэрүүд (үлгүрмүд), урт туулиуд, бэлэн шүлгүүд болон элдэв зүйл бүрийн халимагуудын зан үйл, цээр, дом гэх мэтийн олон зүйл оржээ. Мөн түүнчлэн тус эмхэтгэлд настны өөрийн зохиосон буюу өвлөн уламжлан ирсэн ардын дуунаас 20 гаруй дуу оржээ. Тус дуунууд нь агуулгаараа нутаг усаа магтсан, хүмүүсийн янаг хайрыг илтгэсэн, Сибирийн хүнд хэцүү амьдралын байдлыг харуулсан, эдүгээ цагийн зарим нэгэн үл таалагдах буюу эс таашаагдах зүйлсийг хошигнон шүүмжилсэн гэх мэт олон зүйлийн өнгө аястай байна.

«Ариун сэтгэлээсээ — ерөөлүүд, дууд, шаваашнууд» гэдэг ерөөл магтаал болон дууны эмхэтгэлийг Э. Г. Хейчиева, В. А. Шарманджиевагаас 2007 онд Элст хотод халимаг кирилл үсгээр хэвлүүлж олны хүртээл болгосон байдаг [Эрүн седклэсн 2007]. Тус эмхэтгэлд 386 ерөөл, есөн магтаал болон шавааш, 28 дуу орсон байна. Энэ эмхэтгэлд орсон 28 дууны цөөн хэд нь зохиолын дуу бөгөөд бусад нь ерөнхийдөө ардын дуу байгаа юм.

Халимагийн нэрт дуучин Гарайн Валентина (Һэрэн Валентина)-аас 2006 онд Элст хотод халимаг кирилл үсгээр «Миний жаргалын дуун» гэсэн 120 гаруй дуу бүхий дууны түүврийн ном хэвлүүлсэн байна [Мини жирһлин дун 2006]. Тус ном нь нэг, «Гарайн Валентина (Һэрэн Валентина)-д нэрийдсэн шүлгүүд» (Һэрэн Валентинад зориулж бичсэн шүлгүүд гэсэн утга бүхий үг); хоёр, «Гарайн Валентина (Һэрэн Валентина)-гийн бичсэн ерөөлүүд болон шүлгүүд»; гурав, «Ут дууд (Урт дуунууд)»; дөрөв, «Ахар дууд»; тав, «Домборт хэлдэг дуунууд»⁸⁷ гэсэн таван хэсгээс бүрдсэн аж. Урт дуудын хэсэгт нь «Самбарын гурван толгой», «Саяг саяг саарал», «Сөөм хамартай францис», «Нуур дунд нугас сайхан» гэх мэт 15 дуу орсон ба ахар дууны хэсэгт «Хээмээ» (Кеемэ), «Актүвин гол», «Галуу шувуу», «Дураны дуун»⁸⁸ гэх мэт 52 дуу орсон байна. Домборын хэлдэг дуудын хэсэгт нь «Арван долоотой Алиман хүүхэн», «Бичхэн хээр морин», «Шаркаа Баркаа» (Шарка Барка) гэх мэт 55 дуу орсон байна. Энэхүү дуунуудын олонх нь ардын дуу бөгөөд үүний дотор нь мөн бас хэд хэдэн зохиолчийн зохиосон дуу ч оржээ. Мөн эмхэтгэгчээс тус дуунуудын түүвэрт орсон 120 гаруй дууныхаа ая болгоныг нь таван эгшиг бүхий нотоор тэмдэглэж олны хүртээл болгосон байна.

К. Н. Улюмжиева 2009 онд Халимагийн «Гэрэл» хэвлэлийн газраас халимаг болон орос хоёр хэлээр «Халимагийн шүлэглэлгэний дээж» гэсэн ном хэвлүүлсэн юм [Поэзия Калмыкии 2009]. Тус номонд ардын аман зохиол, эх бичгийн болон орчийн үеийн халимаг зохиолчдын шүлэглэсэн зохиолын зүйлсийг оруулсан байна. Тус номонд Халимагийн «Жангар», шүлэглэсэн аман зохиол болон «Мазан баатар», «Убаши хаан», «Сөөм хамартай францис», «Агчийн уулын бэтэг», «Алтай дээр нь гарахлаа», «Гэртээсээ гараад явна», «Актүвин голын усан», «Коокуу» («Кооку»), «Төгрээш» («Төгрэш»), «Бомборжаан» («Бумбржан») гэдэг 10 дуу орсон байна.

⁸⁷ Домборт хэлдэг дуунууд — Ойрад-Халимагийн товшуурч нар товшууртаа оруулан товшуурдаж болох нэг хэсэг ардын дуу байдаг. Товшуурч товшуурдахад хүмүүс ч түүнийг даган дуулж биелдэг нэг хэсэг дуу байдаг. Энэ нь ийм маягийн дуунуудыг хэлж буй.

⁸⁸ Дураны дуу (дурна дуун) — энэ нь хайрын дуунууд, янаг амрагийн дуунууд гэсэн утга бүхий.

2010 онд Халимагийн соёл түүх судлах хүрээлэнгээс доктор Б. Б. Манджиева (Халимаг нэр нь Манжийн Баяртай)-аас «Алтан цээжтэй хэлмэрч Боктаан Шаня (Боктан Шаня)» гэсэн хүний хэлсэн аман зохиолын эмхэтгэлийг халимаг кирилл үсгээр Элст хотод хэвлүүлсэн билээ [[Алтан чеежтэ келмрч 2010](#)]. Манжийн Баяртайгийн тус эмхэтгэлд оруулсан аман үлгэр, зүйр цэцэн үг, оньсого, дуу болон зан үйлийн холбогдол бүхий зүйлүүд нь хошууд үлгэрч Боктаан Шанягаас 2001–2008 оны хооронд бичлэг хийж тэмдэглэж авсан зүйлс юм. Тус эмхэтгэлийн хошуудын дууны хэсэгт дөрвөн дуу оржээ. Эмхэтгэгчээс тус эмхэтгэлдээ үлгэрч Боктаан Шанягийн тухай судалсан урт оршил бичсэнээс гадна үлгэрүүдийнхээ хойно үгсийн тайлбар, зүүлт, нэрсийн хэлхээ зэргийг хавсаргасан байна.

2011 онд «Т. С. Тягиновагийн аман уран үгийн хөрөнгөөс» гэсэн 37 үлгэр бүхий нэг үлгэрчийн хэлсэн үлгэрийн эмхэтгэлийг Элст хотод халимаг кирилл үсгээр хэвлүүлсэн билээ [[Тягинован 2011](#)]. Тус эмхэтгэлийг Халимагийн соёл түүх судлах хүрээлэнгээс эрдэмтэн доктор Б. Б. Горяева хэвлэлд бэлтгэсэн бөгөөд үүнд нь 37 аман үлгэр оржээ. Эмхэтгэлд энэхүү 37 аман үлгэрээс гадна ерөөлүүд, ут дуун (урт дуу), үлгүүрүүд болон цэцэн үгнүүд, тайлбартай туульс (оньсого гэсэн утга бүхий үг) болон зан үйл зэрэг олон төрлийн зүйлс орсон байна. Эмхэтгэгчээс эмхэтгэлийн хойно үгсийн тайлбар, нэр үгсийн хэлхээс, үлгэрчийн сурвалжлага болон үлгэрчийн тухай судалсан судалгааны хоёр өгүүллийг хавсаргажээ. Тус эмхэтгэлийн ут дуудын хэсэгт 18 дуу орсон бөгөөд эмхэтгэлд мөн энэ үлгэрчийн 1967–1996 оны хооронд зохиосон таван дууг ч оруулан хэвлэсэн байна.

Халимаг Улсын Их сургуулийн багш, профессор Н. Ц. Биткеевээс 2011 онд «Монгол туургатны ардын аман зохиол — шинжилгээ болон текстүүд» гэсэн цувралын нэгдүгээр боть болох «Халимагийн аман зохиол» гэсэн номыг Москва–Элстд хэвлүүлсэн юм [[Фольклор народов 2011](#)]. Тус ном нь «Жангар», «Гэсэр», хууч яриа болон домог, халимагийн аман зохиолын жижиг төрөл зүйлүүд, зан үйлийн аман зохиол, Шинжааны Ойрад-Халимагийн аман зохиолууд болон хавсралт гэсэн хэд хэдэн хэсгээр бүрэлдсэн байна. Зан үйлийн аман зохиол дотор 20 дуу орсон бөгөөд зохиогчоос энэхүү 20 дуугаа халимаг кирилл үсэг болон орос орчуулгатайгаар хэвлүүлжээ. Мөн түүнчлэн дууны аяыг таван эгшигт нотоор тэмдэглэж өгсөн байна.

2014 онд И. М. Болдыревагаас «Гэрэлтсэн сувсан — Б. М. Санжиевагийн бичүүлж авсан аман уран үгийн хөрөнгөөс» гэсэн номыг халимаг кирилл үсгээр Элст хотод хэвлүүлсэн юм [[Герлтсн сувсн 2014](#)]. Эмхэтгэлд орж бүхий аман зохиолыг Б. М. Санжиевагийн 1972–1974 оны хооронд халимаг туульч (үлгэрч гэсэн утга бүхий үг) нараас тэмдэглэж үлдээсэн зүйлс болно. Эмхэтгэн хэвлүүлэгч И. М. Болдыревагаас тус эмхэтгэлд орж бүхий зүйлсээ нэг, домог болон туужис⁸⁹, хоёр, ут туульс (аман үлгэр гэсэн утга бүхий үг), гурав, хэмээлгэн, дөрөв, далын шинж, тав, шаваашнууд; зургаа, хуучин цагийн дууд (эртний дуунууд; ардын дуунууд гэсэн утга бүхий үг), долоо, үлгүүрүүд (үлгүрмүд) болон цэцэн үгүүд (зүйр цэцэн үг болон цэцэн үгнүүдийг зааж буй), найм, тайлбарт туульс (оньсогогыг зааж буй), ес, гарын

⁸⁹ Домог болон туужис — энэ нь домог үлгэр болон домгийг зааж байгаа.

хуруудын хүүндвэр⁹⁰, арав, ерөөл гэж арван ангид хуваажээ. Мөн түүнчлэн зан үйлийн холбогдол бүхий зүйлс ч нэлээд орсон буй. Дууны ангид нь 98 дуу орсон бөгөөд түүгээ шастир дууд⁹¹, ут дууд, халимаг хүүхэн улсын туск (тухай) дууд (энэ нь халимаг хүмүүсийн эмэгтэй хүмүүсийн тухай дуунууд гэсэн утга бүхий юм), советин цагийн дууд⁹² хэмээн хуваасан байна. Эмхэтгэн хэвлүүлэгчээс тус эмхэтгэлдээ Б. М. Санжиевагийн тухай бичсэн оршлоос гадна эмхэтгэлийн хойно нь аман зохиолыг хэлэгч нарын танилцуулга, тэдний нэр овог, хэлсэн он жил сар өдөр, орон газар зэргийг маш нарийнаар танилцуулсаны хамт нэр үгсийн хэлхээсийг үйлдэж өгсөн байна.

2015 онд «XIX зууны Халимаг ардын дуу болон ая» гэсэн номыг Халимагийн Соёл түүх судлах хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б. Х. Борлыковагаас Элст хотод хэвлүүлсэн байна [Борлыкова 2015]. Тус ном нь өмнөх үг, текст болон нот (XIX зууны халимаг ардын дуу болон ая), толь зэрэг хэдэн хэсгээс бүрэлдсэн байна. Өмнөх үгийн хэсэгт нь XIX зууны эхнээс сүүл хүртэл Орос болон Европ дахинд халимаг дууг цуглуулан эмхэтгэсэн буюу хэвлүүлсэн түүхийн байдлыг өгүүлсэн байна. Халимаг дууны текст болон аяын хэсэгт нь XIX зууны Орос болон Европын эрдэмтдээс цуглуулан тэмдэглэсэн буюу эмхэтгэн хэвлүүлсэн Халимаг ардын дууны текст болон аяыг оруулсан байна. Энэ эмхэтгэл нь XIX зуунд цуглуулсан буюу хэвлүүлсэн халимаг ардын дууг ерөнхийд нь оруулж чадсан нэлээд сайн ном болсон хэмээн хэлж болох юм.

Эрдэмтэн судлаачид Ойрад-Халимагийн ардын дуунууд болон бусад аман зохиолын төрөл зүйлийг аль эртнээс цуглуулан тэмдэглэж олон ном дэвтэр, эмхэтгэлүүдээ хэвлүүлж ирснээр үл барам мөн сонин сэтгүүл дээр ч нийтэлсээр ирсэн билээ. Халимаг нутагт XX зууны эхнээс эхлэн зүйл бүрийн сонин сэтгүүлүүд хэвлэгдэн олны хүртээл болсоор ирэв. Тухайлбал, «Ойрадын занги», «Улаан халимаг», «Улаан тээг», «Тангачийн занги», «Тээгийн гэрэл», «Лениний зам», «Лениний ач нар», «Улаан загасч», «Халимаг үнэн», «Зөвлөлтийн Халимаг тангач» гэх мэтийн сонинууд гарч байсан ба «Ойрадын занги», «Халимаг коммунист намын занги», «Халимаг область», «Ажлын ард», «Манай хэл», «Тээгийн гэрэл» гэх мэтийн сэтгүүл ч хэвлэгдэж иржээ. Түүнчлэн зарим нь одоо хүртэл мөн хэвлэгдсээр байна. Жишээлбэл, долоо хоногт зургаан дугаар хэвлэгдэх «Халимаг үнэн» сонин 1957 оноос одоо хүртэл хэвлэгдсээр байгаа бөгөөд «Тээгийн гэрэл» гэдэг утга зохиолын сэтгүүл мөн 1957 оноос эдүгээ хүртэл хэвлэгдсээр буй. Энэхүү олон сонин сэтгүүлд маш олон Халимагийн аман зохиолын эх хэрэглэгдэхүүн хэвлэгджээ. Үүний дотор мөн ардын дуунууд ч олон буй. Мөн түүнчлэн энэхүү хугацаанд Ойрад-Халимагийн ардын дууг судалсан эрдэм шинжилгээний судалгааны ном болон өгүүллүүд ч нэлээд олон гарсан байна.

⁹⁰ Гарын хуруудын хүүндвэр (нарин хурхдин күүндвр) — ардын тоглоом наадмын дотор хүүхэд хуруугаа атгаж хэлэлцэн нааддаг нэг зүйлийн наадам.

⁹¹ Шастир дуунууд (шастр дуд) — энэ нь голдуу гэгээн богд, хувилгаан хутагт, лам хувраг болон ноёд сайдуудад дуулдаг ут дуунуудыг зааж буй.

⁹² Советин цагийн дууд — Зөвлөлтийн цагийн дуунууд гэсэн утгатай.

Дүгнэлт

Дүгнэж хэлэхэд, Ойрад-Халимагийн ардын дуунууд нь XVIII зууны дундаас халимаг хэлээр (тод үсэг, халимаг кирилл үсэг, халимаг латин үсэг, зүйл бүрийн олон улсын галиг, орос маягийн эрдэм шинжилгээний галиг) хэвлэгдэж ирснээр үл барам мөн Орос, Европын улс орны олон хэлээр орчуулагдаж олон ном хэвлэгдэн ирсэн түүхтэй юм. Ойрад-Халимагуудын ардын дуунуудыг эрдэмтэн судлаачдаас сурвалжлан цуглуулах, эмхэтгэх, орчуулах, судлах, хэвлүүлэх ажил нь Монголын бусад овог аймаг, газар орноос тун ч эрт эхэлсэн бөгөөд тэмдэглэн хэвлүүлсэн зүйлс тун өнөр баялаг юм. Энэхүү зүйлс нь өнөөдөр манай хэл болон ардын дуу судлалын ховор нандин зүйл болсоор байгаа билээ. Тийм ч учраас бусад газар орны монгол дуу судалж байгаа эрдэмтэн судлаачид манай ойрад-халимагийн энэ олон дууны тансаг баялаг эх хэрэглэгдэхүүн болон судалгааны ном, өгүүллүүдийг хайн сурвалжлан олж, сайнаар уншиж, Ойрад-Халимагийн хэл хэллэгийг нь зөвөөр ойлгож, эдгээр олон материалыг сайн ашиглахад хүрвэл судалж байгаа судлал нь улам өндөр түвшинд хүрэх болно хэмээн итгэж байна.

Ном зүй

- Алексеева 2009 — *Алексеева П. Э.* Принцесса Нирджидма и книга песен торгутов Китая. Элиста: НПП «Джангар», 2009. 87 с.
- Азиатский журнал 1816 — Азиатский музыкальный журнал. Астрахань, 1816. 25 октября. № 1.
- Алтн чеежтэ келмрч 2010 — Алтн чеежтэ келмрч Боктан Шаня. Хранитель мудрости народной Шаня Боктаев. Сост., предисл., коммент. и прилож. Б. Б. Манджиевой. Элиста: КИГИ РАН, 2010. 172 с. (На рус. и калм. яз.).
- Антология 1962 — Антология калмыцкой поэзии. Сост. С. К. Каляев, И. М. Мацаков, Л. С. Сангаев; Под ред. А. Сусеева. Элиста: Калмгосиздат, 1962. 303 с.
- Өмд булг 1993 — Өмд булг. Ц. К. Жаргаеван фольклорн репертуар. Бүрдэхч, орч статья, бичэд, үүдэврмүдиг барт белдснь Н. Ц. Биткеев (= Живой родник. Фольклорный репертуар Ц. К. Жаргаевой. Сост., вступ. ст., подготовка к изданию Н. Ц. Биткеева). Элиста: АПП «Джангар», 1993. 80 х. (На калм. яз.).
- Өрүн седклэсн 2007 — Өрүн седклэсн: йөрэлмүд, дуд, шавашмуд (= От чистой души: благопожелания, песни, шавашы. Сост. Хейчиева Э. Г., Шарманджиева В. А.) Элст: ЗАОр НПП «Джангар», 2007. 286 с.
- Бадмаев 1971 — *Бадмаев А. В.* Практический самоучитель строкалмыцкой письменности. Элиста: КНИИЯЛИ, 1971. 100 с.
- Биткеев 1987 — *Биткеев Н. Ц.* Калмыцкая народная поэзия. Элиста: Калм. кн. изд-во, 1987. 141 с.
- Биткеев 2005 — *Биткеев Н. Ц.* Калмыцкий песенный фольклор. Элиста: АПП «Джангар», 2005. 213 с.
- Борлыкова 2015 — *Борлыкова Б. Х.* Калмыцкие народные песни и мелодии XIX в. (по архивным и опубликованным материалам). Записи XIX века. Ч. 1. Вступ. ст., сост., предисл., подг. текстов, пер. на соврем. калм. язык и прилож. Б. Х. Борлыковой. Транслит., пер. со старокалм. на соврем. калм. язык Б. В. Меняева. Элиста: НПП «Джангар», 2015. 120 с. (На калм. яз.).
- Владимирцов 1918 — *Владимирцов Б. Я.* Монгольский сборник рассказов из Рагсатантра // Сборник Музея Антропологии и этнографии при АН СССР. Пг.: Акад. 12-я гос. тип., 1918. Т. 5. Вып. 2. С. 401–552.

- Владимирцов 1923а — *Владимирцов Б. Я.* Монголо-ойратский героический эпос. Пер., вступ. ст. и примеч. Б. Я. Владимирцова. Пг.–М.: Гос. изд-во, 1923. 254 с.
- Владимирцов 1923б — *Владимирцов Б. Я.* Волшебный мертвец. М.: Гос. изд-во, 1923. 118 с.
- Владимирцов 1926 — *Владимирцов Б. Я.* Образцы монгольской народной словесности. (С-З. Монголия) / предисл., текст в транскр. Л.: Ин-т живых вост. яз. им. А. С. Енукидзе, 1926. 202 с.
- Владимирцов 1929 — *Владимирцов Б. Я.* Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика. Л.: Издание Ленинградского восточного института, 1929. 435 с.
- Владимирцов 1934 — *Владимирцов Б. Я.* Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм. Л.: Изд-во АН СССР, 1934. 223 с.
- Владимирцов 2005 — *Владимирцов Б. Я.* Работы по монгольскому языкознанию. М.: Вост. лит., 2005. 950 с.
- Герлтсн сувсн 2014 — Герлтсн сувсн. Б. М. Санджиеван бичулж авсн амн урн үгин көрнэгэс (= Сияющая жемчужина. Фольклорные материалы, собранные собирателем Б. М. Санджиевой). Записи 1972–1974 гг. На калм. яз. Вступ. ст., сост. и подг. текстов, прил. И. М. Болдыревой. Элиста: КИГИ РАН, 2014. 222 с.
- Джангар 1911 — Джангар. Героическая поэма калмыков, с приложением вновь открытой и впервые издаваемой третьей главы, в оригинальном калмыцком тексте. Ред. А. М. Позднеев. СПб.: Тип. Имп. Акад. наук, 1911. 97 с.
- Дуулич 1958 — Дуулич, теегм, дуул. Хальмг дуудын хуранһу. Хураж диглэд барлснь Жимбин Б. (= Пой, степь моя, пой. Сост. Б. Джимбиев). Элст: Хальмг дегтр һарһач, 1958. 330 х.
- Дуулцхатн 1962 — Дуулцхатн: Өмн цага болн өдгэ цага хальмг дуд. Цуглуулж, диглж һарһснь Санһжин Б. (= Пойте: старинные и современные калмыцкие песни. Сост. Б. Сангаджиева). Элст: Хальмг дегтр һарһач, 1962. 115 х.
- Калмыцкая хрестоматия 1915 — Калмыцкая хрестоматия для чтения в старших классах калмыцких народных школ. Сост. А. М. Позднеев. Изд. 3-е, испр. и доп. Пг.: Тип. И. Бораганского, 1915. 196 с.
- Калян Санж 2005 — *Калян Санж.* Теегин булг. Элст: Хальмг дегтр һарһач (= Степной родник), 2005. 238 с.
- Кел өргжүллһнэ дегтр 1994 — *Калян А.* Кел өргжүллһнэ дегтр. Дунд школын 5–9-гч класст дасх дегтр (= Книга для развития речи. Книга для чтения в 5–9 классах средней школы). Элст: Хальмг дегтр һарһач, 1994. 232 х.
- Листопадов 1998 — *Листопадов А. М.* Калмыцкие песни, записанные в Денисовской станице Сальского округа в ноябре 1902 года. Публикация В. К. Шивляновой // Из истории русской фольклористики. СПб.: «Дмитрий Буланин», 1998. Вып. 4–5. С. 541–560.
- Мини жирһлин дун 2006 — Мини жирһлин дун. Һэрэн Валентина цуглуул (= Песня моей жизни. Сост. В. Гаряева). Элст: АОр «НПП „Джангар”», 2006. 165 х.
- Небольсин 1852 — *Небольсин П. И.* Очерки быта калмыков Хошоутовского улуса. СПб.: Тип. К. Крайя, 1852. 190 с.
- Нефедьев 1834 — *Нефедьев Н.* Подробные сведения о волжских калмыках, собранные на месте. СПб.: Тип. К. Крайя, 1834. 286 с.
- Ниржидмаа 2013 — *Ниржидмаа.* Монголын арван найман дуу шүлэг. [франц]-ын М. Бүжигмаа орчуулав, Д. Таяа буулгаж дэглэв (= Восемнадцать монгольских песен. Пер. с франц. М. Бужигмы, ред. Д. Таяа]. Хуххот (= Хух-Хото): Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо (= Народное изд-во Внутренней Монголии), 2013. 176 с. (На монг. яз.)

- Ниржидмаа 2014 — *Ниржидмаа*. Монголын арван найман дуу шүлэг. Орч. М. Бүжигмаа, ред. Д. Таяа (= Восемнадцать монгольских песен. Пер. М. Бужигмы, ред. Д. Таяа]. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2014. 181 х. (На монг. яз.)
- Номинхана 2008 — *Номинхана Цэрэндорж*. Баруун монголын дөрвөдийн зан үйлийн аман зохиолоос. Нэгдүгээр боть. Ж. Цолоо, Э. Пүрэвжав удиртгал, тайлбар бичив (= Из фольклора западно-монгольских дербетов. Первый том. Введ., коммент. Ж. Цолоо, Э. Пүрэвжава). Улаанбаатар: Содпрес, 2008. 215 х.
- Номинхана 2009а — *Номинхана Цэрэндорж*. Бурхан хааны хөвүүн балчир Бум-Эрдэнэ. Хоёрдугаар боть. Ж. Цолоо, Э. Пүрэвжав удиртгал, тайлбар бичив (= Сын Бурхан хана Бум-Эрдэнэ. Второй том. Введ., коммент. Ж. Цолоо, Э. Пүрэвжава). Улаанбаатар: Содпрес, 2009. 162 х.
- Номинхана 2009б — *Номинхана Цэрэндорж*. Ойрад аман зохиолын сан хөмрөгөөс. Гуравдугаар боть. Э. Пүрэвжав, Ж. Цолоо, Ц. Өнөрбаян удиртгал, тайлбар бичив (= Из собрания ойратского фольклора. Введ., коммент. Ж. Цолоо, Э. Пүрэвжава, Ц. Унурбаяна). Улаанбаатар: Содпрес, 2009. 219 х.
- Номинханов 1935 — *Номинханов Ц.-Д.* Монгол хэлний үсгүүд сурах болон унших дэвтэр (= Книга для изучения монгольского алфавита и чтения). Ташкент: Дундад Азийн улсын дээд сургууль (= Среднеазиатский народный университет), 1935. 123 с.
- Номинхановын 2016 — Ц.-Д. Номинхановын 1924–1925 онд Баруун монголд хийсэн судалгаа. Хоёр боть. Н. Сүхбаатар, Т. Ганцогт монгол кирилл үсэгт буулгав (= Исследования Ц.-Д. Номинханова в Западной Монголии в 1924–1925 гг. Переложение на совр. монгольскую графику Н. Сүхбаатара, Т. Ганцогта) Улаанбаатар: Соёмбо принтинг, 2016.
- Очиров 2006 — *Очиров Н. О.* Мөңк дееж. Живая старина. Из литературного наследия Номто Очирова. Сост., вступ. ст., коммент. Б. А. Бичеева. Элиста: Калм. кн. изд-во, 2006. 397 с.
- Позднеев 1880 — *Позднеев А. М.* Образцы народной литературы монгольских племен. Народные песни монголов. Вып. 1. СПб.: Тип. Имп. академии наук, 1880. 348 с.
- Поэзия Калмыкии 2009 — Поэзия Калмыкии. Антология. На калм. и рус. яз. Ред.: Д. Б. Дорджиева, В. Д. Бадмаева, В. Л. Теленгидова [и др.]. Элиста: ИД «Герел», 2009. 352 с.
- Руднев 1909 — *Руднев А. Д.* Мелодии монгольских племен. Сборник в честь 70-летия Григория Николаевича Потанина. СПб.: Типография В. Ф. Киришаума (отделение), 1909. С. 395–430.
- Рыбаков 1897 — *Рыбаков С. Г.* Музыка и песни уральских мусульман с очерком их быта. Записки Императорской академии наук. По историко-филологическому отделению. Т. 2. № 2. СПб.: Императорская академия наук. 1897. 330 с.
- Сборник песен 1934 — Сборник калмыцких песен. Сост. М. Тритуз. М.: Музгиз, 1934. 51 с.
- Сто песен 1991 — Сто калмыцких народных песен. Сост. Л. И. Цебигов. Элиста: Калм. кн. изд-во, 1991. 128 с.
- Страхов 1810 — *Страхов Н. Н.* Нынешнее состояние калмыцкого народа, с присовокуплением калмыцких законов и судопроизводства, десяти правил их веры, молитвы, нравоучительной повести, сказки, пословиц и песни. СПб.: Тип. Шнора, 1810. 99 с.
- Тахь Зул 1910 — Тахь Зул хааны үлдэл, Тансаг Бумба хааны ач, Үзэн алдар хааны хөвгүүн, Үеийн өнчин Жангарын арван бүлэг (= «Джангар». Десять глав). Петербург, 1910. 336 с.
- Теегин айсмуд 1982 — Теегин айсмуд: Хальмг улсин урдк болн өдгэ цагин дуд (= Мелодии степи: старинные и современные калмыцкие народные песни).

- Хуранһу бүрдэһэчнр Н. К. Волькович, Н. Ц. Эрендженов (= сост. Н. К. Волькович, Н. Ц. Эрендженов). Элст: Хальмг дегтр *harhach*, 1982. 109 х.
- Төрсн һазрин дуд 1989 — Төрсн һазрин дуд (= Песни родной земли). Сост. и автор вступ. ст. Б. Б. Оконов. Элиста: Калм. кн. изд-во, 1989. 245 х.
- Төрсн литератур 1989 — Төрсн литератур. Дунд сурһулин 7-гч болн 8-гч класст умшх дегтр (Книга для чтения на калмыцком языке в 7 и 8 классах). Кичгэ Төлэ, Божан Манца. Элст: Хальмг дегтр *harhach*, 1989. 255 с.
- Төрсн утх зокъял 2012 — Төрсн утх зокъял. Дунд сурһулин нээмдгч класст умшх дегтр (Калмыцкая литература. 8 класс. Учебник для общеобразовательных учреждений) / сост. С. Н. Цеденова, Н. Б. Коксунова. Элиста: ИД «Герел», 2012. 174 с.
- Тягинован 2011 — Т. С. Тягинован амн урн үгийн көрңгэс. Фольклорные материалы из репертуара Т. С. Тягиновой. Сост. Б. Б. Горяева. Элиста: КИГИ РАН, 2011. 207 с.
- Үксн цогцын хүвлһн 1962 — Үксн цогцын хүвлһн. Монгольск-ойратск туульс. Э. Г. Манжиев орс келнэс орчулв (= Волшебный мертвец. Монгольско-ойратские сказки. Пер. с рус. яз. Э. Г. Манджиева). Элст: Хальмг госиздат, 1962. 92 х.
- Фольклор народов 2011 — Фольклор монгольских народов: исследование и тексты. Т. 1. Калмыцкий фольклор. Сост. Н. Ц. Биткеев. Элиста: НПП «Джангар», 2011. 498 с.
- Хабунова 1998 — *Хабунова Е. Э.* Калмыцкая свадебная обрядовая поэзия. Исследование и материалы. Элиста: Калм. кн. изд-во, 1998. 224 с.
- Хабунова 2005 — *Хабунова Е. Э.* Һулмт (= Очаг. Обряды и обрядовый фольклор жизненного цикла калмыков). Элиста: Изд-во КалмГУ, 2005. 205 х.
- Хальмг дуд 1977 — Хальмг дуд. Хальмг дуудын хуранһу (= Калмыцкие песни. Сборник калмыцких песен). Ред. болн бүрдэһэч Буджала Е. (ред. и сост. Е. Буджалов) Элст: Хальмг дегтр *harhach*, 1977. 156 х.
- Хальмг өдгэ 1961 — Хальмг өдгэ болн хуучна дуд. Дуудин айсинь ясснь Чонкушов Петр, үгмүдинь ясснь Эрендженов Нарма. М., 1961. 41 с.
- Хальмг фольклор 1941 — Хальмг фольклор. Бүрдэж кеснь, нүр үгнь болн темдгүдинь бичснь Леежнэ Церн, Шалвра Һэрэ (= Калмыцкий фольклор. Сост. Ц. О. Леджинов, Г. М. Шалбуров). Элиста: Калм. госиздат, 1941. 466 с.
- Хальмг хуучн 1962 — Хальмг хуучн болн өдгэ цагин дуд (= Калмыцкие народные и современные песни: для голоса с ф.-п. (баяном)) / обработка М. Грачева; Рус. текст М. Лапирова; общ. ред. Н. Эрендженова. М.: Сов. композитор, 1962. 72 с.
- Хаслунд 2010 — *Хаслунд Х.* Монгол хүн монгол бурхад (= Монголия: люди и боги). Улаанбаатар: Битпресс хэвлэлийн газар, 2010. 365 х.
- Хонхо 1925–1927 — Хонхо: Калмыцкая хрестоматия. Вып. I. *Revnicе*: Издание калмыцкой комиссии культурных работников в ЧСР, 1925. 134 с.; Вып. II. 1926. 314 с.; Вып. III. 1927. 255 с.
- Хорьдугаар зууны Халимагийн... 2005 — Хорьдугаар зууны Халимагийн эрдэмтэн болон жуулчлагчдын Шинжааны ойрадын тухай тэмдэглэл. О. Тайван орчуулан буулгаж тайлбарлав (= Заметки калмыцких ученых и путешественников XX в. о синьцзянских ойратах. Пер. и коммент. О. Тайвана). Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо (Пекин: Изд-во национальностей), 2005.
- Цецн булг 2006 — Цецн булг (= Родник мудрости. Сост. А. П. Амбекова). Элст: ИД «Герел», 2006. 190 с. (На калм. и рус. яз.).
- Шонхор 1995 — Шонхор. Баһ сурһулин 3-гч классин умшх дегтр. Бүрдэһэчнр Жинцана Е., Манжин Н., Онтан З. (Шонхор. Книга для чтения в 3 классе начальной школы. Сост. Е. Джинцанова, Н. Манджиев, З. Онтаева). Элст: Хальмг дегтр *harhach*, 1995. 271 х.

- Яцковская 1988 — Яцковская К. Н. Народные песни монголов. М.: Наука, 1988. 253 с.
- Birtalan 2011 — Birtalan Agnes (Ed.). Kalmyk Folklore and Folk Culture in the mid-19th Century. Philological Studies On the Basis of Gabor Balint of Szentkatolna's Kalmyk Texts. Ed. by A. Birtalan with the collaboration of T. G. Basangova (Bordzhanova). Budapest, 2011. 380 p. [=Филологические исследования калмыцкого фольклора и народной культуры в XIX веке, основанные на западномонгольских (калмыцких) текстах Габора Балинта из Сенткатолны. Изд. подгот. А. Бирталан при сотрудничестве с Т. Г. Басанговой. Будапешт, 2011. 380 с.] (на англ. и калм. яз.).
- Kalmükische Sprachproben 1909 — Kalmükische Sprachproben. Teil 1. Kalmükische Märchen. 1–2. Ges. u. hrsg. von G. J. Ramstedt. Helsinki: Suomalais-Ugrilainen Seuran Toimituksia=Mémoires de la Société Finno-Ougrienne (27/1–2), 1909. 154 p.
- Nirgidma 1937 — Nirgidma. Dix-huit chants et poèmes mongols. Regueillis per La princesse Nirgidma de Torhout. Et transcrits par Madame Humbert-Sauvageot. Avec notations musicales, texte mongol, commentaries et traductions. — Paris: Librairie orientaliste Paul Geuthner, 1937. 175 p.
- Pallas 1776 — Pallas P. S. Sammlungen historischer Nachrichten über die Mongolischen Völkerschaften. Bd. 1. St. Petersburg: Gedruckt bey der Kayserlichen Akademie der Wissenschaften, 1776–1801. XIV. 232 c.
- Pallas 1881 — Pallas P. S. Sammlungen historischer Nachrichten über die Mongolischen Völkerschaften. Bd. 2. St. Petersburg: Gedruckt bey der Kayserlichen Akademie der Wissenschaften, 1801. X. 438 c.
- Ramstedt 1974 — Ramstedt G. J. Nordmongolische Volksdichtung. Helsinki: Suomalais-Ugrilainen Seura, 1974. 322 p.
- Ramstedt, Aalto 1955–1956 — Ramstedt G. J., Aalto P. Kalmükische Sprichwörter und Rätsel // Aikakauskirja – Journal de la Societe Finno-Ougrienne. Vol. 58. Helsinki: Suomalais-Ugrilainen Seura, 1955–56. Pp. 1–38.
- Ramstedt, Aalto 1965 — Ramstedt G. J., Aalto P. Torgutische Lieder // Aikakauskirja – Journal de la Societe Finno-Ougrienne. Vol. 67. Helsinki: Suomalais-Ugrilainen Seura, 1965. Pp. 1–14.
- Ramstedt, Balinov, Aalto 1962 — Ramstedt G. J., Balinov S., Aalto P. Kalmükische Lieder // Aikakauskirja Journal de la Societe Finno-Ougrienne. Vol. 63. Helsinki: Suomalais-Ugrilainen Seura, 1962. Pp. 1–127.
- 兰司铁著 2014 — G. J. 兰司铁著:《七次 东方旅行记》 泰米尔译, 呼和浩 特: 内蒙古人民出版社, 2014年.
- 亨宁·哈士纶1999 — 亨宁·哈士纶:《蒙古的人和神》, 徐孝详译, 乌鲁木齐: 新疆人民出版社, 1999年. 共328页。

References

- Alekseeva P. E. Princess Nirjidma and the Book of Torghut Songs (China). Elista: Dzhangar, 2009. 87 p. (In Russ.)
- Ambekova A. P. The Spring of Wisdom. Elista: Gerel, 2006. 190 p. (In Kalm. and Russ.)
- Aziatskiy muzykal'nyi zhurnal. Astrakhan. 1816, October 25. No. 1. (In Russ.)
- Badmaev A. V. Old Kalmyk Script: A Practical Guide. Elista: Kalmyk Research Institute of Language, Literature and History, 1971. 100 p. (In Russ. and Kalm.)
- Birtalan A. (ed.). Kalmyk Folklore and Folk Culture in the mid-19th Century. Philological Studies on the Basis of Gabor Balint of Szentkatolna's Kalmyk Texts. Basangova (Bordzhanova) T. G. (co-ed.). Budapest, 2011. 380 p. (In Eng. and Kalm.)
- Bitkeev N. Ts. (comp.) Folklore of Mongolic Peoples: Study and Texts. Vol. 1: Kalmyk Folklore. Elista: Dzhangar, 2011. 498 p. (In Kalm. and Russ.)
- Bitkeev N. Ts. (comp.) The Living Spring: Folklore Repertory of Ts. K. Dzhargaeva. Bitkeev N. Ts. (foreword, prep.). Elista: Dzhangar, 1993. 80 p. (In Kalm.)
- Bitkeev N. Ts. Kalmyk Folk Poetry. Elista: Kalmyk Book Publ., 1987. 141 p. (In Russ.)

- Bitkeev N. Ts. Kalmyk Song Folklore. Elista: Dzhangar, 2005. 213 p. (In Russ.)
- Boldyreva I. M. (comp.) The Shining Pearl: Folklore Materials Collected by B. Sandzhieva. Recordings of 1972–1974. Boldyreva I. M. (foreword, etc.). Elista: Kalmyk Humanities Research Institute of RAS, 2014. 222 p. (In Kalm.)
- Borlykova B. Kh. Kalmyk Folk Songs and Melodies: 19th Century. Archival and Published Materials.. Vol. 1: 19th-Century Recordings. Borlykova B. Kh. (comp., foreword, etc.). Menyayev B. V. (translit.). Elista: Dzhangar, 2015. 120 p. (In Kalm.)
- Budzhala E. (ed., comp.) Kalmyk Songs: Collected Texts. Elista: Kalmyk Book Publ., 1977. 156 p. (In Kalm.)
- Chonkushov P., Erendzhenov N. (eds.) Old and Modern Songs of the Kalmyks. Moscow, 1961. 41 p. (In Kalm.)
- Dordzhieva D. B. et al. (eds.) Poetry of Kalmykia: Anthology. Elista: Gerel, 2009. 352 p. (In Kalm. and Russ.)
- Dzhimbiev B. (comp.) ‘Sing, My Steppe, Sing!’ Elista: Kalmyk Book Publ., 1958. 330 p. (In Kalm.)
- Dzhintsanova E., Mandzhiev N., Ontaeva Z. (comps.) Shonkhr: (Kalmyk-Language) Reader for 3rd Grade Pupils of Preliminary Schools. Elista: Kalmyk Book Publ., 1995. 271 p. (In Kalm.)
- Erendzhenova N., Grachev M., Lapirov M. (eds.) Kalmyk Folk and Modern Songs. Moscow: Sovetskiy Kompozitor, 1962. 72 p. (In Kalm. and Russ.)
- Garyaeva V. (comp.) The Song of My Life. Elista: Dzhangar, 2006. 165 p. (In Kalm.)
- Goryaeva B. B. (comp.) Folklore Materials Recorded from T. S. Tyaginova. Elista: Kalmyk Humanities Research Institute of RAS, 2011. 207 p. (In Kalm. and Russ.)
- Haslund H. Men and Gods in Mongolia. Ulaanbaatar: Bitpress, 2010. 365 p. (In Mong.)
- Jangar*: A Heroic Epic of the Kalmyks. Supplemented with the Newly Rediscovered Song Three. Pozdneev A. M. (ed.). St. Petersburg: Imperial Academy of Sciences, 1911. 97 p. (In Kalm.)
- Jangar*: Ten Songs (Chapters). Peterburg, 1910. 336 p. (In Kalm.)
- Kalyaev S. K. et al. (comps.), Suseev A. (ed.) Anthology of Kalmyk Poetry. Elista: Kalmgosizdat, 1962. 303 p. (In Kalm.)
- Kalyan A. Reader for 5th–9th Grade Pupils. Elista: Kalmyk Book Publ., 1994. 232 p. (In Kalm.)
- Kalyan S. A Spring in the Steppe. Elista: Kalmyk Book Publ., 2005. 238 p. (In Kalm.)
- Khabunova E. E. Kalmyk Wedding Ritual Poetry: Study and Materials. Elista: Kalmyk Book Publ., 1998. 224 p. (In Russ.)
- Khabunova E. E. The Hearth: Kalmyk Life-Cycle Rites and Related Folklore. Elista: Kalmyk State University, 2005. 205 p. (In Russ.)
- Kheychieva E. G., Sharmandzhieva V. A. (comps.) In All Sincerity: Well-Wishing Verses, Songs, Shavash Texts. Elista: Dzhangar, 2007. 286 p. (In Kalm.)
- Khonkho*: Kalmyk Chrestomathy. Vol. I. Revnice: Kalmyk Commission of Cultural Workers in the CSR, 1925. 134 p.; Vol. II. 1926, 314 p.; Vol. III. 1927, 255 p. (In Kalm.)
- Kichgā T., Bozhan M. Native Literature: Kalmyk-Language Reader for 7th–8th Grade Pupils. Elista: Kalmyk Book Publ., 1989. 255 p. (In Kalm.)
- Leejnā Ts., Shalvra Y. (comps.) Kalmyk Folklore. Elista: Kalmgosizdat, 1941. 466 p. (In Kalm.)
- Listopadov A. M. Kalmyk songs recorded in Denisovskaya stanitsa (Salsky District) in November of 1902, and published by V. K. Shivlyanova. In: Russian Folklore Studies. Glimpses of History. St. Petersburg: Dmitry Bulanin, 1998. Vols. 4–5. Pp. 541–560. (In Russ.)
- Mandzhieva B. B. (comp.) Boktan Shanya: The Guardian of Folk Wisdom. Mandzhieva B. B. (foreword, comment., etc.). Elista: Kalmyk Humanities Research Institute of RAS, 2010. 172 p. (In Russ. and Kalm.)

- Nebolsin P. I. Kalmyks of Khoshoutovsky District: Sketches of Everyday Life. St. Petersburg: K. Kray, 1852. 190 p. (In Russ.)
- Nefediev N. Volga Kalmyks: Detailed Data Collected on Site. St. Petersburg: K. Kray, 1834. 286 p. (In Russ.)
- Nirgidma. Dix-huit chants et poèmes mongols. Regueillis per La princesse Nirgidma de Torhout. Et transcrits par Madame Humbert-Sauvageot. Avec notations musicales, texte mongol, commentaries et traductions. Paris: Librairie orientaliste Paul Geuthner, 1937. 175 p. (In French)
- Nirjidmaa. The Eighteen Mongolian Songs. M. Bujigma (transl.), D. Tayaa (ed.). Hohhot: Inner Mongolia People's Publ. House, 2013. 176 p. (In Mong.)
- Nirjidmaa. The Eighteen Mongolian Songs. M. Bujigma (transl.), D. Tayaa (ed.). Ulaanbaatar: Soembo Printing, 2014. 181 p. (In Mong.)
- Nominkhana Ts. Bum Erdene, the Son of Burkhan Khaan. Vol. 2. Zh. Tsooloo, E. Purevjav (introd., comment.). Ulaanbaatar: Sodpress, 2009. 162 p. (In Mong.)
- Nominkhana Ts. Collected Oirat Folklore Samples. Zh. Tsooloo, E. Purevjav, Ts. Unurbayan (introd., comment.). Ulaanbaatar: Sodpress, 2009. 219 p. (In Mong.)
- Nominkhana Ts. Dorbets of Western Mongolia: Folklore Samples. Vol. 1. Zh. Tsooloo, E. Purevjav (introd., comment.). Ulaanbaatar: Sodpress, 2008. 215 p. (In Mong.)
- Nominkhana Ts. Studies in Western Mongolia: 1924–1925. N. Sükhbaatar, T. Gantsogt (translit.). Ulaanbaatar: Soembo Printing, 2016. (In Mong.)
- Nominkhanov Ts.-D. Classical Mongolian: ABC Book and Reader. Tashkent: Central Asian State University, 1935. 123 p. (In Mong.)
- Ochirov N. O. The Living Ancientry: Glimpses of Nomto Ochirov's Literary Heritage. Bicheev B. A. (comp., foreword, etc.). Elista: Kalmyk Book Publ., 2006. 397 p. (In Russ.)
- Oirats of Xinjiang: Collected Notes of 20th-Century Kalmyk Researchers and Travellers. O. Tayvan (transl., comment.). Beijing: Nationalities Publ. House, 2005. (In Mong.)
- Okonov B. B. (comp.) Songs of Motherland. Okonov B. B. (foreword). Elista: Kalmyk Book Publ., 1989. 245 p. (In Kalm.)
- Pallas P. S. Sammlungen historischer Nachrichten über die Mongolischen Völkerschaften. Vol. 1. St. Petersburg: Imperial Academy of Sciences, 1776–1801. XIV. 232 p. (In Germ.)
- Pallas P. S. Sammlungen historischer Nachrichten über die Mongolischen Völkerschaften. Vol. 2. St. Petersburg: Imperial Academy of Sciences, 1801. X. 438 p. (In Germ.)
- Pozdneev A. M. (comp.) Kalmyk Chrestomathy (Reader) for Senior Classes of Kalmyk Public Schools. 3rd ed., rev. and suppl. Petrograd: I. Boragansky, 1915. 196 p. (In Kalm.)
- Pozdneev A. M. Folk Literature of Mongolian Tribes: (Selected) Samples. Folk Songs of Mongols. Vol. 1. St. Petersburg: Imperial Academy of Sciences, 1880. 348 p. (In Mong. and Russ.)
- Ramstedt G. J. (comp.) Kalmükische Sprachproben. Vol. 1: Kalmückische Märchen. 1–2. Ges. u. hrsg. von G. J. Ramstedt. Helsinki: Suomalais-Ugrilainen Seuran Toimituksia=Mémoires de la Société Finno-Ougrienne (27/1–2), 1909. 154 p. (In Germ.)
- Ramstedt G. J. Nordmongolische Volksdichtung. Helsinki: Suomalais-Ugrilainen Seura, 1974. 322 p. (In Germ.)
- Ramstedt G. J., Aalto P. Kalmückische Sprichwörter und Rätsel. *Aikakauskirja – Journal de la Société Finno-Ougrienne*. 1955–1956. Vol. 58. Pp. 1–38. (In Germ.)
- Ramstedt G. J., Aalto P. Torgutische Lieder. *Aikakauskirja – Journal de la Société Finno-Ougrienne*. 1965. Vol. 67. Pp. 1–14. (In Germ.)
- Ramstedt G. J., Balinov S., Aalto P. Kalmückische Lieder. *Aikakauskirja Journal de la Société Finno-Ougrienne*. 1962. Vol. 63. Pp. 1–127. (In Germ.)

- Rudnev A. D. Melodies of Mongolian Tribes. In: Celebrating Prof. G. N. Potanin's 70th Anniversary of Birth. St. Petersburg: V. F. Kirschbaum, 1909. Pp. 395–430. (In Russ.)
- Rybakov S. G. Muslims of the Urals: A Review of Their Music and Songs, Supplemented with a Sketch of Everyday Life. Ser.: (Scholarly) Notes of the Imperial Academy of Sciences. Department of History and Philology. 1897. Vol. 2. No. 2. 330 p. (In Russ.)
- Sangadzhieva B. (comp.) 'Sing!': Collected Old and Contemporary Kalmyk Songs. Elista: Kalmyk Book Publ., 1962. 115 p. (In Kalm.)
- Strakhov N. N. Kalmyk People: (A Description of) Their Current Conditions, Supplemented with Kalmyk Laws and Procedures, Ten Precepts of Their Faith, a Prayer, a Morality Story, a Folk Tale, Proverbs, and a Song. St. Petersburg: Schnor, 1810. 99 p. (In Russ.)
- The Magic Dead: Tales of Oirat Mongols. Mandzhiev E. G. (transl.). Elista: Kalmgosizdat, 1962. 92 p. (In Kalm.)
- Trituz M. (comp.) Collected Kalmyk Songs. Moscow : Muzgiz, 1934. 51 p. (In Russ.)
- Tsebikov L. I. (comp.) One Hundred Folk Songs. Elista: Kalmyk Book Publ., 1991. 128 p. (In Kalm. and Russ.)
- Tsedenova S. N., Koksunova N. B. (comps.) Kalmyk Literature: Textbook for 8th Grade Pupils. Elista: Gerel, 2012. 174 p. (In Kalm.)
- Vladimirtsov B. Ya. Classical Mongolian and the Khalkha Dialect: A Comparative Grammar. Introduction and Phonetics. Leningrad: Leningrad Institute of Oriental Studies, 1929. 435 p. (In Russ.)
- Vladimirtsov B. Ya. Collected Mongolian-language tales from the Pañcatantra. *Sbornik Muzeja Antropologii i etnografii pri AN SSSR*. 1918. Vol. 5. No. 2. Pp. 401–552. (In Russ.)
- Vladimirtsov B. Ya. Mongolian Linguistics: Collected Papers. Moscow: Vostochnaya Literatura, 2005. 950 p. (In Russ.)
- Vladimirtsov B. Ya. Mongolian Speech Patterns. Vladimirtsov B. Ya. (foreword, transcr.) Leningrad: Yenukidze Institute of Living Oriental Languages, 1926. 202 p. (In Russ.)
- Vladimirtsov B. Ya. Social System of Mongols. Mongolian Nomadic Feudalism. Leningrad: USSR Academy of Sciences, 1934. 223 p. (In Russ.)
- Vladimirtsov B. Ya. The Heroic Epic of Oirat Mongols. Vladimirtsov B. Ya. (transl., foreword, etc.). Petrograd–Moscow: State Publ. House, 1923. 254 p. (In Russ.)
- Vladimirtsov B. Ya. The Magic Dead. Moscow: State Publ. House, 1923. 118 p. (In Russ.)
- Volkovich N. K., Erendzhenov N. Ts. (comps.) Melodies of the Steppe: Old and Modern Kalmyk Folk Songs. Elista: Kalmyk Book Publ., 1982. 109 p. (In Kalm.)
- Yatskovskaya K. N. Folk Songs of Mongols. Moscow: Nauka, 1988. 253 p. (In Mong.)
- 兰司铁著 2014 — G. J. 兰司铁著: 《七次 东方旅行记》 泰米尔译, 呼和浩特: 内蒙古人民出版社, 2014年.
- 亨宁·哈士纶1999 — 亨宁·哈士纶: 《蒙古的人和神》, 徐孝详译, 乌鲁木齐: 新疆人民出版社, 1999年。共328页。